



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр  
сарын 4-ний өдөр

Дугаар 1

Улаанбаатар  
хот

Олборлох үйлдвэрлэлийн ил тод  
байдлын тухай санаачилгыг  
дэмжих тухай

Монгол Улсын эдийн засагт уул уурхайн олборлох үйлдвэрүүдийн эзлэх хувийн жин нэмэгдэж цаашид түргэн хурдацтай өсөх хандлагатай байгааг үндэслэн, олон улсын байгууллагууд, хандивлагч орнуудын уриалга, саналыг харгалзан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Ерөнхий сайд Тони Блэйрийн санаачилсан "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай" санаачилгыг дэмжих нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгыг дэмжсэнтэй холбогдуулан түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ц.ЭЛБЭГДОРЖ

Үйлдвэр, худалдааны сайд

С.БАТБОЛД

Засгийн газрын 2006 оны 1 дүгээр  
тогтоолын хавсралт

**"ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ"  
САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ,  
ХЯНАН ЗОХИЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд
- Гишүүд:
- Үйлдвэр, худалдааны сайд;
  - Сангийн сайд;
  - Байгаль орчны сайд;
  - Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр);
  - Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр);
  - Улсын ерөнхий аудитор (зөвшилцсөнөөр);
  - Үндэсний статистикийн газрын дарга (зөвшилцсөнөөр);
  - Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга;
  - Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх;
  - Уул уурхайн ассоциацийн хүндэт ерөнхийлөгч (тохиролцсоноор);
  - Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор).
- Нарийн бичгийн дарга -Ерөнхий сайдын ахлах зөвлөх.



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 222

Улаанбаатар  
хот

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг  
хангах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2, 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (цаашид “ОУИТБС” гэх)-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл (цаашид “Үндэсний зөвлөл” гэх)-ийг Засгийн газрын байгууллага, ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж, тэдгээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж (цаашид “компаниуд” гэх)-үүд, салбарын мэргэжлийн холбоо (цаашид “мэргэжлийн холбоо” гэх), олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах чиглэлээр эвлэлдэн нэгдсэн иргэний нийгмийн эвсэл (цаашид “иргэний нийгмийн эвсэл” гэх)-ийн дараахь төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байхаар тогтоосугай:

1.1. Засгийн газрын байгууллагын төлөөлөл-6;

1.2. Улсын Их Хурал, түүний харьяа байгууллагын төлөөлөл-4;

1.3. Компаниуд, мэргэжлийн холбоодын төлөөлөл-9, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжийн төлөөлөл-1;

1.4. Иргэний нийгмийн эвслийн төлөөлөл-8;

1.5. Байгаль орчны иргэний нийгмийн эвслийн төлөөлөл-2.

2. Үндэсний зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд, орлогч дарга нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, нарийн бичгийн дарга нь Ерөнхий сайдын ахлах зөвлөх байхаар тогтоосугай.

3. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг Засгийн газрын байгууллага, компаниуд, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн эвслийн дараахь төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

3.1. Засгийн газрын байгууллагын төлөөлөл-10;

3.2. Улсын Их Хурлын харьяа байгууллагын төлөөлөл-1;

3.3. Компаниуд, мэргэжлийн холбоодын төлөөлөл-9, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжийн төлөөлөл-2;

3.4. Иргэний нийгмийн эвслийн төлөөлөл-9;

3.5. Байгаль орчны иргэний нийгмийн эвслийн төлөөлөл-2;

3.6. Ажлын албаны зохицуулагч.

4. Ажлын хэсгийн ахлагч нь Ерөнхий сайдын ахлах зөвлөх, нарийн бичгийн дарга нь ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч байхаар тогтоосугай.

5. Үндэсний зөвлөл болон Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох Засгийн газрын байгууллага, Улсын Их Хурал, түүний харьяа байгууллагын төлөөллийг Монгол Улсын Ерөнхий сайд томилж, чөлөөлж байхаар тогтоосугай.

6. Үндэсний зөвлөл болон Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох компаниуд, мэргэжлийн холбоод, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжийн төлөөллийг Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч, иргэний нийгмийн эвслийн төлөөллийг Иргэний нийгмийн "ТАН" эвслийн зохицуулах зөвлөлийн хурлаар, байгаль орчны иргэний нийгмийн эвслийн төлөөллийг тус эвслийн удирдах байгууллагын хурлаар тус тус хэлэлцэн томилж, чөлөөлөн холбогдох шийдвэрээ Үндэсний зөвлөлийн даргад ирүүлснээр хүчин төгөлдөр болж байхаар тогтоосугай.

7. ОУИТБС-ын хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнд хүргэж хэрэгжүүлэн, шинээр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, түүнийг эзэмших, шилжүүлэх үйл ажиллагаа, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах талаар байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ, газрын тосны талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ, тэдгээрийн хэрэгжилт, ашиглалтын өмнөх гэрээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль хамгаалах ажлын явц, үр дүн, түүнд зарцуулсан зардал зэргийг тус санаачлагад нэмж хамруулахаар тогтоосугай.

8. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох, эзэмших, шилжүүлэх (тусгай зөвшөөрлийг компанийн нэр, баримт бичигтэй нь хамт худалдах асуудал энд бас хамаарна), стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ болон тэдгээрийн хэрэгжилт, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт, экспортын хэмжээг нийтэд ил тод болгох ажлыг 2012 оноос туршилтын журмаар хэрэгжүүлж, үр дүнг Ажлын хэсэг, улмаар Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж жил бүр нийтэд ил тод мэдээлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод үүрэг болгосугай.

9. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Д.Хаянхярваад үүрэг болгосугай:

9.1. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, мөн тэдгээртэй гэрээ байгуулан ажилладаг туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн тухайн жилд улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг, торгууль, хандив, тусламжийн аудит хийсэн тоо баримтад тулгуурлан тайланг гаргаж, нийтэд мэдээлэх ажлыг хэвшил болгон зохион байгуулж байх;

9.2. ОУИТБС-ын Засгийн газрын тайланг улсын хэмжээнд нэгтгэж байгаа Татварын ерөнхий газрын мэдээллийн сүлжээг өргөтгөн сайжруулж, улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдээллийн нэгдсэн санд суурилсан вэб хандлагатай программ хангамж бий болгон төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутагт хурааж байгаа татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж зэрэг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрч байгаа орлогын мэдээг нэгтгэн шуурхай, үнэн зөв гаргах нөхцөлийг бүрдүүлэх, санхүүгийн тайланд нэмж тусгах;

9.3. Энэ тогтоолын 9.1-д заасан тайлангийн анхан шатны мэдээ гаргах төрийн захиргааны төв болон төрийн захиргааны холбогдох байгууллага, орон нутгийн байгууллага гаргасан мэдээгээ татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж байгаа байдалд хяналт тавьж, нийтэд ил тод мэдээлэх;

9.4. Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрсөн уул уурхай, газрын тосны орлогын зарцуулалтын тайланг 2013 оноос эхлэн нийтэд мэдээлж байх бэлтгэл ажлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

10. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Цогтбаатарт үүрэг болгосугай:

10.1. Компаниудын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тэдгээрт оруулсан өөрчлөлт, байгаль хамгаалах талаархи жил бүрийн тайлан, Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.9-д заасны дагуу байгаль орчныг хамгаалах ажилд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн, зарцуулсан, буцаан төлсөн байдлыг аж ахуйн нэгж бүрээр гаргаж, нийтэд ил тод мэдээлж байх;

10.2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргадаг ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах тайланг нийтэд ил тод мэдээлж байх арга хэмжээ авах.

11. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай:

11.1. Тухайн нутаг дэвсгэрт ашигт малтмал, газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж зэрэг орлогын тайланг аудит хийгдсэн санхүүгийн тоо баримтад үндэслэн гаргаж, нийтэд мэдээлэх ажлыг 2012 оноос эхлэн

хэрэгжүүлэх, цаашид уг мэдээг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор тайлагнаж, нийтэд мэдээлэх ажлыг хэвшил болгох;

11.2. Компаниуд болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ОУИТБС-ын дэд зөвлөлийг аймаг, нийслэлийн Засаг даргын орлогчоор ахлуулан орон нутгийн захиргааны байгууллага, компаниуд, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн төлөөллийн 3 талын тэгш оролцоо бүхий бүрэлдэхүүнтэйгээр байгуулан үйл ажиллагаанд нь хяналт тавих;

11.3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тэдгээрт оруулсан өөрчлөлт, байгаль хамгаалах талаар сум, дүүрэгт хүргүүлсэн аж ахуйн нэгжийн жил бүрийн тайлан, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувийг Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8-д заасны дагуу сум, дүүргийн тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт, буцаан төлөлтийн байдлыг аж ахуйн нэгж бүрээр гаргаж, аймаг, нийслэлийн дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн нийтэд ил тод мэдээлж байх;

11.4. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар байгуулсан гэрээ, түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлж байх;

11.5. Нутаг дэвсгэрт нь уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа суманд энэ тогтоолын 11.2-т заасан дэд зөвлөлийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулж ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

12. Компани болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс хүлээн авсан татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, мөн холбогдох гэрээний дагуу авсан төлбөр зэрэг орлогын жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 15-ны дотор татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж байхыг холбогдох яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

13. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг Үндэсний зөвлөлд даалгасугай.

13.1. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлийг баталж, тэдгээрийн хэрэгжилтийн явц, үр дүнг хэлэлцэж, удирдан зохицуулж байх;

13.2. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж байгаа ажлын явц, үр дүнг хэлэлцэн тодорхой чиглэл, үүрэг даалгавар өгч ажиллах;

13.3. ОУИТБС-ын жилийн тайлан, мэдээллийг хэлэлцэн, тайланг аймаг, сумдад хүргэж сурталчлах зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох яам, Засгийн газрын агентлаг, оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлж, үр дүнг нийтэд ил тод мэдээлж байх;

13.4. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байгаа компаниуд, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн эвслийн санал, санаачлагыг дэмжин хамтарч ажиллах;

13.5. Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлын үр дүн, тайлангийн талаар Засгийн газар, улмаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд жил бүр тайлагнаж байх.

14. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Р.Содхүүд даалгасугай:

14.1. Холбогдох хуульд заасан мэдээллийг үнэн зөв гаргаж, нийтэд мэдээлээгүй ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд Ашигт малтмалын тухай хуульд заасан арга хэмжээ авч, энэ талаар Үндэсний зөвлөлд тайлагнаж, нийтэд мэдээлж байх;

14.2. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийг хянан шалгаж, нэгтгэн жил бүрийн 5 дугаар сард багтаан ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд тайлагнаж, нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах.

15. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж, тэдгээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн удирдлагад даалгасугай:

15.1. Улсын болон орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аудит хийсэн санхүүгийн тоо баримтад үндэслэн жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор тайлагнаж, зохих журмын дагуу нийтэд мэдээлж байх, тайланг батлагдсан маягтын дагуу ОУИТБС-ын Ажлын албанд хүргүүлэх;

15.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд зарцуулсан хөрөнгө, хийсэн ажил, түүний үр дүнг тухайн аймаг, сумын иргэдэд ил тод, нээлттэй мэдээлж байх, энэ чиглэлээр орон нутгийн иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах.

16. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Чиг үүрэг батлах тухай” Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 80 дугаар тогтоол, “Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 84 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

С.БАТБОЛД

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

Ч.ХҮРЭЛБААТАР



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 07 сарын 08 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ

(Шинэчилсэн найруулга)

### 48 дугаар зүйл. Мэдээ, тайлан гаргах

... "48.10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийг хэмжээг дараа оны 1-р улиралд багтаан нийтэд мэдээлнэ". ....

### 66 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

... "66.1.2. Энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан албан тушаалтныг 100000-500000 хүртэл, хуулийн этгээдийг 500000-1000000 хүртэл төгрөгөөр торгох;" ...

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

[2009.07.16](#)

Орхон, Улаанбаатар хот

## ӨНГӨН ХАМГААГАХ

### 28 дугаар зүйл. Орхон аймаг, Увс аймгийн өмнөд, хангайн

...28.6.4. Өмнөд аймгийн орхон аймгийн өмнөд аймаг, хангайн өмнөд аймгийн өмнөд аймаг, 35.3-35.5, 36.1, 36.2, 39.1, 45.1, 45.2, 47.1, 47.5, 47.6, 48.7-48.10-д орхон аймаг, хангайн өмнөд аймаг;

### 50 дугаар зүйл. Орхон аймаг, Увс аймгийн өмнөд аймаг, хангайн өмнөд аймаг

... 50.1.2. Өмнөд аймгийн орхон аймаг, хангайн өмнөд аймаг, 35.3-35.5, 36.1, 36.2, 39.1, 45.1, 45.2, 47.1, 47.5, 47.6, 48.7-48.10-д орхон аймаг, хангайн өмнөд аймаг, 35.3-35.5, 36.1, 36.2, 39.1, 45.1, 45.2, 47.1, 47.5, 47.6, 48.7-48.10-д орхон аймаг, хангайн өмнөд аймаг;

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,  
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2013 оны 01 дүгээр  
сарын 3 -ны өдөр

Дугаар 1/3/11

Улаанбаатар хот

Маягт, нөхөх заавар, журам батлах тухай

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, "Нягтлан бодох бүртгэлийн тухай" Монгол улсын хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, "Ашигт малтмалын тухай" Монгол улсын хуулийн 48 дугаар зүйлийн 48.10, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг зохион байгуулах, хянан зохицуулах Үндэсний зөвлөлийн чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

Нэг "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын тайлангийн маягт ОУИТБС-1, ОУИТБС-2, ОУИТБС-3, ОУИТБС-4, ОУИТБС-5, ОУИТБС-6, нөхөх заавар"-ын загварыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Маягт, заавар батлах тухай" Үндэсний статистикийн хорооны дарга, Сангийн сайдын 2011 оны 1-р сарын 26-ны едрийн 1/12/13 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын тайлангийн маягт ОУИТБС-1, ОУИТБС-2, ОУИТБС-3, ОУИТБС-4, ОУИТБС-5, ОУИТБС-6 болон нөхөх заавар"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга /Б.Ганбат/, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч /Х.Ганцогт/ нар түүрэг болгосугай.



## **ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦАА (2010-2014 ОН)-НЫ СТРАТЕГИ**

### **Нэг. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг улс орнуудад нэвтрүүлж байгаа нь**

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (цаашид “ОУИТБС” гэх)-ыг 40 гаруй орон дэмжиж, 20 гаруй улс хэрэгжүүлж байгаагийн дотор хөгжингүй орнуудаас Норвег Улс орж байна. НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2008 оны чуулганаар энэхүү санаачлагыг дэмжин, гишүүн орнуудыг даган мөрдөхийг уриалсан тогтоол гаргасан. Тус санаачлагын удирдлага, аргазүйгээр хангах үүрэг бүхий Олон улсын Удирдах хороо, Нарийн бичгийн дарга нарын газар ажиллаж байна. Олон улсын баталгаажуулалтаар 2 улс санаачлагын “шаардлага бүрэн хангасан орон” гэсэн үнэлгээ авчээ.

### **Хоёр. ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа, түүний үр дүн**

2. “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачлагыг дэмжих тухай” Засгийн газрын 2006 оны 1 дүгээр тогтоолоор санаачлагад Монгол Улс нэгдэн орсныг зарлан, тус санаачлагыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний Зөвлөлийг Ерөнхий сайдаар ахлуулан байгуулсан. Мөн энэхүү санаачлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ажлын хэсэг байгуулж ажиллуулсан. Үндэсний зөвлөл, ажлын хэсэг энэхүү санаачлагыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ирлээ.

3. Засгийн газар, компани, иргэний нийгмийн 3 талын оролцооны хүрээнд тус санаачлагыг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах санамж бичгийг 2007 оны 4 дүгээр сард байгуулж, ажлын төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ирлээ. Компанийн материаллаг төлбөрийн, Засгийн газар материаллаг орлогын тайлан гаргах маягт боловсруулан батлуулж, түүндээ 1 удаа нэмэлт, өөрчлөлт оруулан мөрдөж байна. Дэлхийн банкны дэргэдэх Итгэлийн сангаас 2 удаа буцалтгүй тусламж авч, өдөр тутмын ажлыг хариуцах Ажлын албыг 2007 оны 6 дугаар сард байгуулан ажиллаж байна. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын орон нутгийн салбар зөвлөлийг нийслэл, 11 аймагт байгуулан ажиллаж байна.

4. Ашигт малтмалын тухай хуулийн 48.10-т “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэж заасан нь компанийн тайлан гаргах эрхзүйн үндэс болж байна. “Чиг үүрэг батлах тухай” Засгийн газрын 2007 оны 80 дугаар тогтоолоор төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагуудын санаачилгын талаархи хүлээх чиг үүргийг тодорхойлж өгсөн. Тайлан гаргах сургалтыг 20 гаруй удаа зохион байгуулж, бүс, аймгийн чуулга, орон нутгийн зөвлөгөөн, хөрөнгө оруулагчдын чуулга, оролцогч талуудын хурал, салбарын мэргэжилтний зөвлөгөөн зэрэг олон нийтийг хамарсан олон тооны арга хэмжээнд ажлын хэсгийн гишүүд, ажлын албаны зохицуулагч оролцож, мөн төвийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр санаачлагыг сурталчлан таниулж байна. ОУИТБС-ын талаар товхимол, тайлан, хуанли, гарын авлага, телевизийн баримтат кино зэрэг материал бэлтгэн олон нийтэд хүргэж, веб сайт англи, монгол хэл дээр ажиллуулж, тогтмол баяжуулж байна.

5. Улсын болон орон нутгийн төсөвт татвар, төлбөр хэлбэрээр компанийн материаллаг төлбөрийн 2006 оны тайланг 64 компани, 2007 оны тайланг 102 компани, 2008 оны тайланг 113 компани, 2009 оны тайланг 121 компани тус тус гаргасны дотор газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээтэй компаниудаас хоёрхон компани орж байна. Улсын болон орон нутгийн төсөвт хүлээн авсан материаллаг орлогын тайланг Сангийн яам 2006 онд 134 компанийн нэрээр, 2007 онд 186 компанийн нэрээр, 2008 онд 186

компанийн нэрээр, 2009 онд 363 компанийн нэрээр тус тус гаргаж тайлагналаа. Монгол Улсын ОУИТБС-ын 2006, 2007, 2008 оны оны тайланг гаргаж хэлэлцэн баталлаа.

6. Монгол Улс ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа байдалд олон улсын баталгаажуулалт хийгдэж, 2010 оны 4 дүгээр сарын 15-нд хуралдсан Олон улсын Удирдах хорооны хурлаас манай улсыг “шаардлагыг хангахад ойлтсон орон” гэж дүгнэн шаардлага хангаагүй байгаа 5 үзүүлэлтийг 6 сарын хугацаанд биелүүлэх хугацаатай үүрэг өгөөд байна.

#### **Гурав. Дунд хугацааны стратеги боловсруулах үндэслэл, шаардлага**

7. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх талаархи ололтоо бататгах, тайлангаар илэрсэн зөрүүний учир шалтгааныг тогтоож авлигаас сэргийлэх, уул уурхай, газрын тосны үйлдвэрлэл эрхэлдэг бүх компанийг тайланд хамруулах, орон нутгийн төсвийн орлого, түүний дотор хандивыг бүрэн тайлагнуулдаг болгох, төрийн захиргааны холбогдох байгууллагын үүрэг, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох зэрэг шаардлага тулгарч байна. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх талаар зарим ахиц дэвшил гарч байгаа ч санаачлагын зарчим, шалгуурт заасан шаардлагыг бүрэн хангах, сүүлийн үед олон улсын байгууллагаас дэвшүүлж байгаа тус санаачлагыг өргөжүүлэх талаархи бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Компани, төрийн захиргааны байгууллага, иргэний нийгэм зэрэг оролцогч байгууллагын чадавхийг бэхжүүлэх хэрэгтэй байна. Эдгээр нь ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацаа (2010-2014 он)-ны стратеги боловсруулах үндэслэл, шаардлага болж байна.

#### **Дөрөв. Дунд хугацааны стратегийн эрхэм зорилго, стратегийн зорилт, үйл ажиллагааны зорилт**

8. Энэхүү дунд хугацааны бодлогын баримт бичгийн эрхэм зорилго нь ОУИТБС-ын зарчим, шалгуурыг Монгол Улсад бүрэн хэрэгжүүлж хангах явдал мөн.

9. Энэхүү эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан стратегийн зорилтыг дэвшүүлж байна:

9.1. ОУИТБС-ын эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

9.2. Тайланд хамрагдах хүрээг өргөтгөж, зөрүүг илрүүлэх, илэрсэн зөрүүг арилгах зөвлөмжийг уг санаачилгын зарчимд нийцүүлэн үргэлжүүлэн хэрэгжүүлэх;

9.3. Санхүүгийн бодит дэмжлэгийг бий болгох;

9.4. Улс төрийн хүсэл сонирхол, иргэний нийгмийн хяналтыг нэмэгдүүлэх;

9.5. ОУИТБС-ын хүрээнд цаашид орлогын зарцуулалт, тусгай зөвшөөрөл, байгаль орчны нөхөн сэргээх ажил, гэрээний ил тод байдлыг хангах чиглэлээр өргөтгөх талаар олон улсын түвшинд гарч байгаа саналыг судалж хэрэгжүүлж эхлэх;

9.6. Чадавхийг бэхжүүлэх.

10. Дээрх стратегийн зорилтуудыг дараахь үйл ажиллагааны зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

10.1. “ОУИТБС-ын эрх зүйн үндсийг бүрдүүлэх” стратегийн зорилтын хүрээнд:

10.1.1. ОУИТБС-ын талаархи олон улс, гадаад орны эрх зүйн ололт, туршлагыг судалж ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд танилцуулах;

10.1.2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл болон холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах;

10.1.3. уул уурхай, газрын тосны үйлдвэрлэлээс улсын болон 1орон нутгийн төсөвт материаллаг орлого бүрдүүлдэг төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагын үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

10.1.4. Засгийн газар, эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичгийг судалж, нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах;

10.1.5. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд уг санаачлагыг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны оновчтой хэлбэрийг сонгон ажиллах.

10.2. “Тайланд хамрагдах хүрээг өргөтгөж, зөрүүг илрүүлэх, илэрсэн зөрүүг арилгах зөвлөмжийг уг санаачилгын зарчимд нийцүүлэн үргэлжүүлэн хэрэгжүүлэх” стратегийн зорилтын хүрээнд:

10.2.1. Олон улсын баталгаажуулалтын дүн, зөвлөмжийг цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;

10.2.2. ОУИТБС-ын зарчим, шалгуур, түүнийг Монгол Улсад хэрэгжүүлсэн дүн, цаашид өргөжүүлэх чиглэлээр компаниуд, иргэний нийгмийн байгууллага, иргэдэд мэдээлэл тогтмол өгч байх;

10.2.3. Аж ахуйн нэгжээс гаргасан болон Засгийн газрын тайланд аудит хийлгэх ажлыг тухайн онд нь багтаан зохион байгуулах;

10.2.4. Тайлан гаргах маягт, зааврыг нөхцөл байдалтай уялдуулан шинэчилж байх;

10.2.5. Үндэсний зөвлөлийн хуралдааныг тогтмолжуулах;

10.2.6. тайлан гаргаагүй, эсхүл буруу гаргасан аж ахуйн нэгж, төрийн захиргааны байгууллагын удирдлага, албан тушаалтны талаар нийтэд тогтмол мэдээлж, хариуцлага тооцож байх;

10.2.7. Монгол Улсын ОУИТБС-ын тайлангаар гарсан зөрүүг улс, компанийн нэрээр мэдээлж, иргэний хяналтыг бий болгох;

10.2.8. Тайлангаар гарсан зөрүүний шалтгааныг илрүүлэх шалгалт хийх хуулийн этгээдийг хууль тогтоомжид тусган батлуулж ажиллах;

10.2.9. Тайлангийн зөрүүг шалгах чиглэлээр иргэний нийгмийн байгууллагатай хамтарсан хяналтын механизмыг бий болгон хэрэгжүүлэх.

10.3. “Санхүүгийн бодит дэмжлэгийг бий болгох” стратегийн зорилтын хүрээнд:

10.3.1. Монгол Улсын ОУИТБС-ын нэгдсэн тайлан гаргах аудитын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх;

10.3.2. Монгол Улсын ОУИТБС-ын нэгдсэн тайланд ороогүй аж ахуйн нэгжүүдийн тайланд тулгалт хийх, тайлангийн зөрүүг шалгах, зөвлөгөө авах зэрэг зардлыг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

10.3.3. ОУИТБС-ын ажлын албаны зардлыг хандивлагч нарт үргэлжлүүлэн тавьж санхүүжүүлэх төсөл хэрэгжүүлэх;

10.3.4. Тус санаачлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг авах чиглэлээр банк, санхүү, компанийн төлөөлөлтэй харилцаа холбоо тогтоон хандивлагч олж хамтран ажиллах.

10.4. “Улс төрийн хүсэл сонирхол, иргэний нийгмийн хяналтыг нэмэгдүүлэх” стратегийн зорилтын хүрээнд:

10.4.1. ОУИТБС-ын талаар хэрэгжүүлж байгаа ажлын дүн, цаашдын зорилтын талаар Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулж холбогдох чиглэл авч байх;

10.4.2. ОУИТБС-тай холбоотой чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв, орон нутгийн бүх шатны байгууллагын удирдлага, холбогдох ажилтны чиг үүрэгт энэхүү санаачлагын хүрээнд хэрэгжүүлэх ажлыг тусгадаг болох;

10.4.3. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тавигдаж байгаа зорилт, нөхцөл байдалтай уялдуулан шинэчилж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах;

10.4.4. Санаачлагын хүрээн дэх хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг шалгаж тайлагнадаг болох.

10.5. “ОУИТБС-ын хүрээнд цаашид орлогын зарцуулалт, тусгай зөвшөөрөл, байгаль орчны нөхөн сэргээх ажил, гэрээний ил тод байдлыг хангах чиглэлээр өргөтгөх талаар олон улсын түвшинд гарч байгаа саналыг судалж хэрэгжүүлж эхлэх” стратегийн зорилтын хүрээнд:

10.5.1. Ашигт малтмалын газар, Нээлттэй нийгэм форумас хэрэгжүүлж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн “Ажиглагч” төслийг түшиглэж, 2011 оноос туршилтын тайлан гаргаж Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн нийтэд ил тод мэдээлэх арга хэмжээ авах;

10.5.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн зардал, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн байгаль орчны нөхөн сэргээлтийн тайланг нийтэд мэдээлдэг болгох ажлыг 2011 оноос эхлэн холбогдох яамтай хамтран хэрэгжүүлэх;

10.5.3. Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдээс орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөрийн орлогын зарцуулалтын тайланг гаргаж төвд мэдээлэхийн хамт 2011 оноос эхлэн аймаг, сумын Засаг даргын Тамгын газар нийтэд мэдээлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

10.5.4. Уул уурхайн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний борлуулалт, экспорт, хөрөнгө оруулалтын ил тод байдлыг хангах арга хэмжээг судалж 2012 оноос туршилтын журмаар Эрдэс баялаг, эрчим хүчний яамтай хамтран хэрэгжүүлж эхлэх;

10.5.5. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг судалж 2011 оноос туршилтын журмаар Эрдэс баялаг, эрчим хүчний яамтай хамтран хэрэгжүүлж эхлэх;

10.5.6. Монгол Улсын ОУИТБС-ын дэлгэрэнгүй тайланг хураангуй хэлбэрт оруулж нийтэд сурталчилж байх.

10.6. “Чадавхийг бэхжүүлэх” стратегийн зорилтын хүрээнд:

10.6.1. Компанийн болон Засгийн газрын тайлан гаргах, нийтэд мэдээлэх зорилготой сургалтын одоогийн хэлбэрийг өргөтгөж, “сургалтын модуль” боловсруулж хэрэгжүүлэх, ажлын байранд түшиглэсэн сургалт явуулах зэргээр тайланг үнэн зөв гаргах, мэдээлэх чадавхийг бэхжүүлэх;

10.6.2. Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн гишүүдэд зориулсан мэдээлэл, үйлчилгээг өргөжүүлж, мэдлэг чадавхийг бэхжүүлэх ажлыг төлөвлөгөөтэй явуулах;

10.6.3. санаачлагад хамтран оролцогч болон сонирхогч иргэний нийгмийн төлөөлөлд иргэний хяналт, бодлогод нөлөөлөх арга, хэлбэрийн талаар хамтран ажиллах;

10.6.4. компанийн засаглал, хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх чиглэлээр холбогдох төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

10.6.5. ОУИТБС-ын ажлын албанд аудитын тайлангийн тулгалт хийх, тайлангийн зөрүүг илрүүлэх үүрэг бүхий орон тоо бий болгох, үйл ажиллагааны чадавхи бий болгох;

10.6.6. ОУИТБС-ын үндсэн зарчим, шалгуур, түүнийг Монгол Улсад хэрэгжүүлж байгаа онцлог, үр дүн, бусад улсад хэрэгжүүлж байгаа үр дүнг харьцуулан судлах, түүнийг нийтэд мэдээлэх чадавхийг иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн ажилтнуудад бий болгож, энэ ажлыг гэрээгээр хэрэгжүүлэх;

10.6.7. Монгол Улсаас ОУИТБС-ын олон улсын Удирдах хороонд сонгогдсон төлөөллийн үүргийг сайн гүйцэтгэж, цаашид байнгын төлөөлөлтэй болгон ажиллуулах хэмжээнд хүртэл чадавжуулах бодлого баримтлах;

10.6.8. Сонирхогч аудитын компаниудад зориулсан “олон улсын баталгаажуулалт хийх чадавхи”, “Монгол Улсын нэгдсэн тайланд биеэ даасан аудит хийх чадавхи” бий болгох төрөлжсөн болон эчнээ сургалт зохион байгуулах, энэ чиглэлээр олон улсын Нарийн бичгийн дарга нарын газарт санал тавих;

10.6.9. ОУИТБС-ын мэдээлэл, сурталчилгаа явуулах, оролцогч талуудын харилцааны асуудлыг шинжлэх чадавхи бий болгох.

11. Дунд хугацааны стратегийн хүрээнд дэвшүүлсэн стратегийн зорилт, үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

12. Стратегийн зорилт, үйл ажиллагааны зорилт нэг бүрийн шалгуур үзүүлэлтийг ажлын алба боловсруулж, ажлын хэсэг баталж мөрдөнө.

13. Дунд хугацааны стратегийн хэрэгжилтийг ажлын хэсэг үнэлж дүгнэн Үндэсний зөвлөлийн хуралдаанд жил бүр тайлагнана.

14. Энэхүү дунд хугацааны стратегийн бодлогын баримт бичигт оролцогч 3 талын зөвшилцсөнөөр нэмэлт, өөрчлөлт оруулна.

Үндэсний зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн  
хуралдаанаар хэлэлцэн батлав.

## МОНГОЛ УЛСАД ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2014 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

### Зорилт:

**1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга, тэдгээрийн зарчмууд болон стандартыг нэвтрүүлэх** - (Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр),

**2. ОУИТБС-ын шинэ стандартыг ханган биелүүлэх**- (1.Олон талт оролцогчдын ажлын хэсгээс үр дүнтэй хяналт тавих; 2. ОУИТБС-ын тайланг хугацаанд нь нийтэд мэдээлэх; 3. Олборлох үйлдвэрлэлтэй холбоотой үндсэн мэдээллийг тайланд оруулах; 4. Олборлох үйлдвэрлэлээс Засгийн газрын хүлээн авсан нийт орлого, газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас Засгийн газарт төлсөн бүх материаллаг төлбөрийг ил тод болгон ОУИТБС-ын иж бүрэн тайлан гаргах; 5. Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын дагуу мэдээллийн баталгааг хангах; 6.ОУИТБС-ын тайлан нь ойлгомжтой, иж бүрэн, идэвхтэй сурталчилсан, олон нийтэд хүртээмжтэй, олж авахад хялбар, олон нийтийн хэлэлцүүлэгт ашиглагдахуйц байх; 7.Олон талт оролцогчдын ажлын хэсгээс ОУИТБС-ын хэрэгжилтэнд гарч буй үр нөлөө, үр дүнг үнэлж, олж авсан сургамжиндаа тулгуурлан хариу арга хэмжээ авч байх;)

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцаж хэрэгжүүлэх байгууллага	Хамтрах байгууллага	Зардлын эх үүсвэр	Хэмжих үзүүлэлт	Стандартын шаардлага
<b>Нэг. ОУИТБС-ын шинэ стандартыг нэвтрүүлэх хүрээнд</b>							
1	2012 оны Олборлох үйлдвэрлэлийн улсын хэмжээний үндсэн мэдээлэл, үйлдвэрлэл, борлуулалт, тусгай зөвшөөрлийн олголт, хөдөлгөөнийг судалж, Монгол Улсын 2012 оны нэгтгэл тайланд нэгтгэх	1 дүгээр сар	АМГ, ГТГ, ЦЭГ	УУЯ, Ажлын алба	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	3.5; 3.9- 3.10
2	2012 онд хийгдсэн томоохон хайгуулын ажлуудын мэдээг гаргаж, Монгол Улсын 2012 оны нэгтгэл тайланд нэгтгэх	1 дүгээр сар	АМГ, ГТГ, ЦЭГ	УУЯ, Ажлын алба	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	3,3
3	2012 оны Олбордох үйлдвэрлэлийн улсын хэмжээний санхүү татварын орчин, орлого зарцуулалтын мэдээг гаргаж, Монгол Улсын 2012 оны нэгтгэл тайланд нэгтгэх	2 дугаар сар	СЯ, ТЕГ	СЯ, Ажлын алба	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	3,2 3,7 3,8
4	2012 онд ОУ-ээс эдийн засагт оруулсан хувь нэмрийн мэдээг гаргаж, Монгол Улсын 2012 оны нэгтгэл тайланд	2 дугаар сар	СЯ, УУЯ	УУЯ, Ажлын алба	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	3,4



	нэгтгэх						
5	ОУ-ийн томоохон компаниудын Засгийн газар, орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээг ил тод болгох, мөн тэдгээр компаниудын нөлөө бүхий эздийг ил тод болгох чиглэлээр Ажлын хэсэг байгуулж ажиллаж, үр дүнг 2012 оны тайланд нэгтгэх	3 дугаар сар	АМГ, ГТГ, ЦЭГ, МУУҮА, Нүүрс Ассоциаци	СЯ, Ажлын алба	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	3.11 3.12
6	Олборлох үйлдвэрлэлийн төрийн өмчит компаниудын хувь эзэмшлийн (хамтарсан болон салбар компани үүнд хамаарна) мэдээг 2012 оны эцсийн байдлаар гарган, Монгол Улсын 2012 оны нэгтгэл тайланд нэгтгэх	4 дүгээр сар	ТӨХ, Эрдэнэс МГЛ	СЯ, Ажлын алба	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	3.6
7	2012 оны эцсийн байдлаар хүчин төгөлдөр байгаа Бүтээгдэхүүн хуваах гэрээний судалгаа, хүлээн авсан орлогын тайланг гаргаж Монгол Улсын 2012 оны нэгтгэл тайланд нэгтгэх	5 дугаар сар	ГТГ	УУЯ, СЯ, Ажлын алба	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	3.12
8	2012 онд Хүлээн авсан нийгмийн үйлчилгээ, дэд бүтэц, татаасын мэдээг аймаг бүрээр гаргаж, Монгол Улсын 2012 оны нэгтгэл тайланд нэгтгэх	6 дугаар сар	Аймгуудын ЗДТГ	СЯ, Ажлын алба	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	4.1
9	2012 оны орон нутгийн шилжүүлгийн мэдээг аймаг бүрээр гаргаж, Монгол Улсын 2012 оны нэгтгэл тайланд нэгтгэх	7 дугаар сар	СЯ, Төсвийн газар	СЯ, Ажлын алба	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	3.7, 4.1
10	Компаниудын ОУИТБС-ын тайлангийн аудитын баталгаажуулалтыг шийдвэрлэх арга замыг судлах	9 дугаар сар	СЯ, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар	СЯ, Ажлын алба	Ажлын алба 300,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	5

11	Засгийн газрын байгууллагуудын ОУИТБС-ын тайлангийн аудитын баталгаажуулалтыг шийдвэрлэх арга замыг судлах	10 дугаар сар	СЯ, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар	СЯ, Ажлын алба	Ажлын алба 300,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	5
<b>Хоёр. Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгдсэн тайлан боловсруулах</b>							
12	Тайланд шинэ стандартын дагуу нэмж 2014 оны Ажлын төлөвлөгөөний 1-9 дүгээр зүйлд заасан ажлын дүнг оруулан, хэвлэн нийтлүүлэх	10 дугаар сар	Ажлын алба	Ажлын хэсэг	Ажлын алба 1,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
13	2012 оны нэгдсэн тайланг ОУ-ын НБДНГ-т хүргүүлэх	11 дүгээр сар	Ажлын алба	Ажлын хэсэг	Ажлын алба 200,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	2
14	Монголын ОУИТБС-ын 2013 оны үйл ажиллагааны тайлан гаргах, хэвлэн нийтлүүлэх	1 дүгээр сар	Ажлын алба	Ажлын хэсэг	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	7.2 а
15	ОУИТБС-ын Үндэсний тайланд аудитын консорциумын жил бүр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтээр хийсэн мониторингийн дүнд тулгуурлан шаардлагатай зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр ажлын төлөвлөгөө боловсруулах	1 -4 дүгээр сар	Ажлын алба, Иргэний нийгмийн төлөөлөл	Ажлын хэсэг	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	7
15.1	Ажлын албаны дэргэд мэдээллийн сан хөмрөг байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлэх	2-6 сар	Ажлын алба	Ажлын хэсэг	Ажлын алба	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
15.2	Ажлын албаны орон тоог эхний ээлжинд бүртгэлийн ажилтнаар нэмэгдүүлэх	1-3 сар	АСИ	Ажлын алба	ЕСБХБ	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
<b>Гурав. МОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлан</b>							
16	Компани, Засгийн газраас ОУИТБС-ын 2013 оны тайлан гаргах	2- 4 дугаар сар	СЯ, ТЕГ, АМГ, ГТГ, ЦЭГ Ажлын алба	МУУҮА, СЯ	Бүх талууд	5 дугаар сарын 15- ны дотор	5
17	Аудиторын консорциумын тендерийн баримт бичгийг боловсруулах, сонгон шалгаруулалт ,	2 –5 дугаар Сар	Ажлын алба	Үнэлгээний хороо	Ажлын алба 200,000 төг	3 дугаар сарын 1- ний дотор	5

17.1	Тендерийн баримт бичгийн боловсруулалт	1-2 дугаар сар	Ажлын алба	Үнэлгээний хороо	Ажлын алба 100,000 төг	3 дугаар сарын 1-ний дотор	5
17.2	Консерцумын сонгон шалгаруулалт	4-5 дугаар сар	Ажлын алба	Үнэлгээний хороо	Ажлын алба 100,000 төг	6 дугаар сарын 1-ний дотор	5
18	Ажлын хэсгийн гишүүдээс худалдан авалтын семинарт суулгаж, худалдан авалтын АЗ гэрчилгээтэй болгох	1-2 дугаар сар	Ажлын алба	Ажлын алба	Ажлын алба 200,000 төг	3 дугаар сарын 1-ний дотор	5
19	Шалгарсан консерциумтай гэрээ байгуулах, ажил эхлүүлэх, нэгтгэлийг зохион байгуулах, хэлэлцэх, батлах	7-12 дугаар сар	Ажлын алба	ЗГХЭГ, Үнэлгээний хороо	Ажлын алба 200,000,000 төг	6 дугаар сарын 30-ны дотор	5
<b>Дөрөв. Чадавхийг бэхжүүлэх, сургалт зохион байгуулах хүрээнд</b>							
20	Компаниудын нягтлан бодогч нарын сургалт- 50 хүн	1 дүгээр сар	Ажлын алба	АМГ	Ажлын алба 3,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
21	Компаниудын нягтлан бодогч нарын сургалт- 50 хүн	2 дугаар сар	Ажлын алба	АМГ	Ажлын алба 3,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
22	Төрийн захиргааны байгууллагуудын тайлан гаргадаг ажилтнуудын сургалт- 60 хүн	4 дүгээр сар	Ажлын алба	СЯ, ТЕГ	Ажлын алба 3,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
23	Нутгийн захиргааны байгууллагуудын тайланг гаргадаг ажилтнуудын сургалт- 30 хүн	5 дугаар сар	Ажлын алба	ТЕГ	Ажлын алба 4,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
24	Аймаг, дүүргийн Засаг даргын орлогч нарын сургалт- 30 хүн	6 дугаар сар	Ажлын алба	Аймгуудын ЗДТГ	Ажлын алба 4,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
25	Орон нутгийн иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээлийн ажилтнуудын чадавхийг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах- 20 хүн	7 дугаар сар	Ажлын алба	Иргэний нийгмийн төлөө	Ажлын алба 5,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
<b>Тав. Орон нутгийн түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүрээнд</b>							
26	Аймаг, нийслэлийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх	3 дугаар сар	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Ажлын алба	Ажлын алба 15,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6

27	Сонгогдсон аймгуудад ОУИТБС-ын мэдээлийн төв байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	5 дугаар сар	Аймаг, нийслэлийн дэд зөвлөл	Ажлын алба	Ажлын алба 20,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
28	Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөрийн орлого, түүний зарцуулалтын тайланг гаргаж төвд болон нийтэд мэдээлэх	6 дугаар сар	Аймаг, нийслэлийн дэд зөвлөл	Ажлын алба	Ажлын алба 1,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
29	Хойд бүсийн чуулга уулзалт, сургалт	6 дугаар сар	Ажлын хэсэг, Ажлын алба	Аймгуудын ЗДТГ	Ажлын алба 5,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
30	Төвийн бүсийн чуулга уулзалт, сургалт	7 дугаар сар	Ажлын хэсэг, Ажлын алба	Аймгуудын ЗДТГ	Ажлын алба 5,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
31	Баруун хойд бүсийн чуулга уулзалт, сургалт	9 дүгээр сар	Ажлын хэсэг, Ажлын алба	Аймгуудын ЗДТГ	Ажлын алба 10,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
32	Зүүн бүсийн чуулга уулзалт, сургалт	10 дугаар сар	Ажлын хэсэг, Ажлын алба	Аймгуудын ЗДТГ	Ажлын алба 5,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
33	Уул уурхай бүхий аймгуудад ОУИТБС-ын чуулган зохион байгуулах	жилдээ	Аймаг, нийслэлийн дэд зөвлөл, Иргэний нийгмийн төлөөлөл	Ажлын хэсэг, Ажлын алба	-	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
<b>Зургаа. Хэвлэл мэдээллийн ажлын хүрээнд</b>							
34	Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны хураангуй тайланг улс, аймгаар хэвлэн нийтлэх, нийтэд мэдээлэх	10 дугаар сар	Ажлын алба	Иргэний нийгмийн төлөөлөл, МУУҮА, ЗГХЭГ	Ажлын алба 10,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
35	ОУИТБС Монгол Улсад эмхэтгэл /англи, монгол хэл дээр/ хэвлэх, түгээх	11 дүгээр сар	Ажлын алба	Ажлын хэсэг	Ажлын алба 5,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
36	ОУИТБС-ын тайлангийн зарим мэдээг цахим хандалтаар, зурган байдлаар	сар бүр	Ажлын алба	Ажлын хэсэг	Ажлын алба 20,000,000	Заасан хугацаандаа	6

	үзүүлэх - 2011-2012 он (Цахим газрын зураг)				төг	хэрэгжсэн эсэх	
37	Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн хуралдааны тухай хэвлэлийн бага хурал зохион байгуулах	Тухай бүр	Ажлын алба	ЗГХЭГ	Ажлын алба 3,000,000 төг	Ажлын хэсэг 4-өөс доошгүй, Үндэсний зөвлөл 2-оос доошгүй удаа хуралдсан байх	6
38	Телевизийн тусгай нэвтрүүлэг бэлтгэн явуулах	Тухай бүр	Ажлын алба	ЗГХЭГ	Ажлын алба 10,000,000 төг	Хагас жилд 1 удаа зохион байгуулсан байх	6
38	ОУИТБС-тай холбоотой мэдээлэл, сурталчилгааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулах	сар бүр	Ажлын алба	Ажлын хэсэг	Ажлын алба 20,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
39	ОУИТБС-ын Үндэсний анхдугаар чуулганыг зохион байгуулах	11 дүгээр сар	Ажлын алба	Ажлын хэсэг	8,000,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
40	Компаниудад зориулсан “Ил тод байдлын шилдэгийг шалгаруулах” арга хэмжээ зохион байгуулах	12 дугаар сар	Ажлын алба	Ажлын хэсэг	Ажлын алба 500,000 төг	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
<b>Долоо. Олон улс, гадаад арга хэмжээний чиглэл</b>							
41	Гадаад улсуудтай туршлага солилцох, сургалтанд хамрагдах, төлөөлөгчид ирүүлэх	1-12 дугаар сар	Ажлын алба	Бүх талууд	Ажлын алба 2,000,000 төг	Жил 1- ээс доошгүй удаа зохиогдсон байх	6
<b>Найм. Европын сэргээн босголт хөгжлийн банкны төслийн төлөвлөгөө - Төслийн нийт санхүүжилт 353,454 евро /2011-2014/</b>							
42	ОУИТБС- ын тухай хуулийн төслийг олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулна (Үндэсний зөвлөлөөр батлуулах хүртэл).	4 дүгээр сар	АСИ	Ажлын хэсэг	ЕСБХБ	Улсын Их хуралд өргөн барих хүртэл	3,2
43	ОУИТБС-ын талаар сургалт, семинар зохион байгуулах ажлууд	1 дүгээр сар	АСИ	Ажлын хэсэг	ЕСБХБ	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
43.1	Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн гишүүдэд зориулсан семинар зохион байгуулах	1 дүгээр сар	АСИ	Ажлын хэсэг	ЕСБХБ	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6

43.2	ОУИТБС-ын оролцогчдын нэгдсэн семинар зохион байгуулах	1 дүгээр сар	АСИ	Ажлын хэсэг	ЕСБХБ	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
43.3	ОУИТБС-ын талаар хэвлэл мэдээллийн байгууллагад зориулсан семинар	1 дүгээр сар	АСИ	Ажлын хэсэг	ЕСБХБ	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
44	Олон нийттэй харилцах, санаачлагын талаарх мэдээлэл түгээх ажлын хүрээнд ОУИТБС-ын харилцааны шинэчилсэн стратегийг хамтран боловсруулж Ажлын хэсэгт хүлээлгэн өгнө. Мөн түүнчлэн олон нийтэд мэдээлэл түгээх ажил 2 зохион байгуулна.	2 дугаар сар	АСИ	Ажлын хэсэг	ЕСБХБ	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
45	Цахим тайлан, тайлангийн маягтыг шинэчлэх, турших ажил зохион байгуулах	6 дугаар сар	АСИ	Ажлын хэсэг	ЕСБХБ	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6
46	Хууль эрх зүй, цахим тайлагналын гадаад судалгаа	3 дугаар сар	Техникийн дэд хороо	Ажлын хэсэг	ЕСБХБ	Заасан хугацаандаа хэрэгжсэн эсэх	6

**Монгол Улсын ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг, Ажлын алба**

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 23-ны хуралдаанаар хэлэлцэн, зөвлөмж болгов.

## **ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ**

### **Нэг. Ерөнхий зүйл**

1. Энэхүү дүрмийн зорилго нь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (цаашид “Санаачилга” гэх)-ыг орон нутагт хангах ажлыг удирдан зохион байгуулах, салбарын засаглалын ил тод байдал, хариуцлагыг сайжруулах үүрэг бүхий дэд зөвлөл (цаашид “дэд зөвлөл” гэх)-ийн харилцааг зохицуулахад оршино.

2. Дэд зөвлөл нь нутгийн захиргааны байгууллага, олборлох үйлдвэрлэл эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллага/иргэд гэсэн гурван талт (цаашид “талууд” гэх) оролцогчдын тэнцүү төлөөллөөс бүрдсэн, зөвшилцлөөр шийдвэр гаргадаг ардчилсан зарчмаар ажилладаг бүтэц байна.

3. Дэд зөвлөл нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах чиглэлээр гарсан хууль тогтоомж, Санаачилгын олон улсын үндсэн зарчим, шаардлагыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хянан зохицуулах үндсэн зорилготой.

4. Дэд зөвлөл нь Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Татварын тухай хууль, Төсвийн тухай хууль холбогдох бусад хууль тогтоомж, журам, шийдвэр, “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 190 болон 2012 оны 222 дугаар тогтоолууд, МУ-ын нэгдэн орсон ОУИТБС-ын олон улсын зарчим, шаардлагыг удирдлага болгон ажиллана.

5. Дэд зөвлөл нь засаг захиргааны нэгжийн түвшинд Санаачилгыг хэрэгжүүлэхдээ оролцогч талууд нягт хамтран ажиллахаа илэрхийлж, харилцан ойлголцолын санамж бичиг байгуулж хамтын ажиллагаагаа баталгаажуулна.

6. Харилцан ойлголцолын санамж бичигт ОУИТБС-ын хүрээнд гарсан хууль, тогтоомж, зарчим, шаардлагыг сахин баримтлах, ил тод байдлыг салбарын өдөр тутмын соёл болгож хэрэгжүүлэх, санаачилгыг нийтэд ойлгомжтой хүртээмжтэйгээр түгээн сурталчилж таниулахааталууд хүлээн зөвшөөрч тэмдэглэсэн байна.

7. Дэд зөвлөл нь хууль дээдлэх, эрх тэгш шударга оролцоо, харилцан бие бие хүндэтгэх, хүчирхийллээс ангид, үл ялгаварлах зарчмуудад тулгуурлан ажиллана.

### **Хоёр. Дэд зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт**

8. Дэд зөвлөлийг уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор байгуулна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол нь Засаг дарга,

иргэний нийгмийн байгууллагуудын хурал, Багийн Иргэдийн Нийтийн хурал, компаниудын хурлын шийдвэрт үндэслэсэн байна.

9. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дэд зөвлөлийг байгуулах, дэд зөвлөлийн тайланг хэлэлцэх, олон талт хэлэлцүүлэг зохион байгуулж талуудын тайланг олон нийтээр хэлэлцүүлэх, жилийн төсвийг батлах, хяналт тавих үүрэг хүлээнэ.

10. Аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга нь төрийн төлөөллийг томилох, чөлөөлөх, дэд зөвлөлийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах, санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлэх, шаардлагатай үед үнэн бодит мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

11. Дэд зөвлөлийн дарга нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч дарга байна.

12. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд орох нутгийн захиргааны байгууллага, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж, тэдгээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж (цаашид “компаниуд” гэх)-үүд, салбарын мэргэжлийн холбоо, (цаашид “мэргэжлийн холбоо” гэх), тухайн орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд/иргэдийн төлөөллийн тоог Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тэгш тэнцүү тогтооно.

13. Аймаг, нийслэл, сум дүүргийн дэд зөвлөлийн бүрэлдэхүүний төлөөллийг дараахь байдлаар томилж, чөлөөлнө:

13.1. Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах нутгийн захиргааны байгууллагын төлөөллийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон тоонд нийцүүлэн Засаг дарга томилж, чөлөөлнө.

13.2. Дэд зөвлөлд орж ажиллах иргэний нийгмийн төлөөллийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон тоонд нийцүүлэн тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын хурлаас, сумын түвшинд иргэний нийгмийн байгууллага байхгүй тохиолдолд иргэдийг баг, хорооны иргэдийн нийтийн хурлаас 2 жилийн хугацаатай томилж, чөлөөлнө.

13.3. Дэд зөвлөлд орж ажиллах компаниудын төлөөллийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон тоонд нийцүүлэн тухайн нутаг дэвсгэрт олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниудын хурлаас 2 жилийн хугацаатай томилж, чөлөөлнө. Сонгогдсон компани төлөөлөл нь тухайн компани хувьд шийдвэр гаргах түвшний удирдлага байна.

13.4. Дэд зөвлөлд орж ажиллах иргэний нийгэм/ иргэд, компаниуд төлөөллөө сонгох хурал зохион байгуулахад нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газраас дэмжлэг үзүүлж зарлах, байраар хангах үүрэгтэй бөгөөд төлөөллийг



хэрхэн сонгосон тухай тэмдэглэл бүхийшийдвэрийг талуудаас авч Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

13.5. Дэд зөвлөлд орж ажиллах талуудын төлөөлөлд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж мэргжлийн холбоод, хэвлэл мэдээлэл, эмэгтэйчүүд, залуучуудзэрэгтөлөөллийн ардчиллыг өргөнөөр хангана.

13.6. Дэд зөвлөлд орж ажиллаж буй иргэний нийгмийн байгууллага/ иргэд нь үйл ажиллагаа, бодлогын хувьд төр болон компаниас хараат бус, нийгмийн шударга ёсны төлөө ажилладаг байна.

13.7. Оролцогч талууд өөрийн төлөөллийн ахлагчтай байна. Оролцогч талуудын ахлагчийг тухайн оролцогч тал дотооддоо зөвшилцөн нэр дэвшүүлж батласан шийдвэрээдэд зөвлөлийн хуралдаанд мэдэгдсэнээр талуудын төлөөллийн ахлагч хүчин төгөлдөр болно.

13.8. Оролцогч талуудын төлөөллийн ахлагч нь дараах эрх, үүрэгтэй байна.

13.8.1. Төлөөллийн нэрийн өмнөөс дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн талаар санал тавих, эсэргүүцэл илэрхийлэх, асуудлыг хойшлуулан хэлэлцэх хугацаа авах эрхтэй;

13.8.2. төлөөллийн талын гишүүдээ дэд зөвлөлийн хуралдаанд бүрэн оролцуулах, өөрийн талаас хуралдаанд оруулах асуудлын бэлтгэлийг хангах;

13.8.3. дэд зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ өгөх, хэрэгжилтийг шаардах;

13.8.4. олон талт хэлэлцүүлэгт өөрийн талын төлөөллөө хамруулах, тайлагнах, мэдээлэл сурталчилгаа хийх;

14. Оролцогч талуудын төлөөллийн гишүүд нь өөрийг нь сонгон ажиллуулсан тухайн бүлэгтэй нягт холбоотой ажиллан, мэдээлэл түгээх, санаачилга болон дэд зөвлөлийн үйл ажиллагааг сурталчилах, дэд зөвлөлийн шийдвэрт төлөөллөөсөө санал авч нэгтгэн байр суурийг илэрхийлэх зэрэг төлөөллийн ардчиллын зарчмыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Үүргээ хэрэгжүүлээгүй буюу зөрчсөн гишүүнээ оролцогч тал хугацаанаас нь өмнө эргүүлэн татаж болно.

15. Дэд зөвлөл нь нарийн бичгийн даргатай байх бөгөөд дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд багтана. Аймаг, нийслэлийн нарийн бичгийн даргын үүргийг Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, эсхүл түүнтэй ижил чиг үүрэг бүхий албан тушаалтан хариуцна. Сум, дүүргийн нарийн бичгийн даргын үүргийг уул уурхай, байгаль орчны асуудал эрхэлсэн байцаагч, эсхүл түүнтэй ижил чиг үүрэг бүхий албан тушаалтан хариуцан ажиллана.

16. Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дэд зөвлөлийн хуралдааны бэлтгэл хангах, зохион байгуулах, хуралдааны материалыг баримтжуулан архивлах, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад санаачилгын Олон улсын үндсэн зарчим, шаардлагуудад нийцүүлэхэд туслах үүрэг хүлээнэ

17. Дэд зөвлөлийн үйл ажиллагаа, Санаачилгатай холбоотой мэдээлэл авах байрыг Иргэний танхим, Нийтийн номын сан зэрэг аль болох иргэдэд тогтмол нээлттэй, хүртээмжтэй мэдээлэл хүрэх цэгт байрлуулна.

### **Гурав. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр**

18. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Дэд зөвлөлийн хуралдааныг дэд зөвлөлийн дарга буюу Засаг даргын орлогч дарга удирдана.

19. Дэд зөвлөл нь дарга, түүний эзгүйд орлож байгаа гишүүн, эсхүл хуралдааныг удирдахаар эрх шилжүүлсэн төлөөллийн ахлагчдын зөвшөөрснөөр хуралдана. Нарийн бичгийн дарга нь хуралдаанаар хэлэлцэх асуудал, хуралдааны товыг дарга, түүний эзгүйд орлож байгаа гишүүн, эсхүл хуралдааныг удирдахаар эрх шилжүүлсэн төлөөллийн ахлагчтай зөвлөлдөн, гишүүдэд зарлаж, хуралдаанаар хэлэлцэх материалыг хэвлэмэл хэлбэрээр хурал болохоос ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргүүлнэ. Дэд зөвлөлийн гишүүний зөвшөөрснөөр цахим хэлбэрээр хүргүүлж болно.

20. Хуралдаан нь дэс дугаар, дэг, журамтай байна. Хуралдааны дэг болон журмыг Дэд зөвлөлийн анхдугаар хуралдаанаар хэлэлцэн батална.

21. Дэд зөвлөлийн хуралдааныг хагас жилд нэг удаа хуралдуулах бөгөөд дэд зөвлөлийн даргын эсвэл зөвлөлийн гишүүдийн олонхи, эсвэл оролцогч талуудын аль нэг тал санал болгосоноор ээлжит бус хуралдаан зохион байгуулна.

22. Дэд зөвлөлийн хуралдаан Санаачилгыг орон нутагтаа хангах бодлого, хөтөлбөр, жил бүрийн ажлын төлөвлөгөө, түүний төсөв боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлж ИТХ-д тайлагнаж гарсан дүгнэлт шийдвэрийг аймгийн дэд зөвлөлд хүргүүлэх үүрэг хүлээнэ.

23. Дэд зөвлөлийн хуралдаан гишүүдийн гуравны хоёр бүрдсэнээр хүчин төгөлдөр хуралдах ирцтэй болно. Бичгээр саналаа ирүүлсэн гишүүнийг ирсэнд тооцох бөгөөд саналыг хуралдаан даргалагч гишүүдэд уншиж сонсоно. Хуралдааны шийдвэр олонхийн саналаар гарна. Гэхдээ аль нэг талын төлөөлөл бүхлээрээ сөрөг санал өгсөн асуудлыг хойшлуулж, дараагийн хурлаар нэмэлт тодруулга, үндэслэл гаргах үндсэн дээр хэлэлцүүлж шийдвэрлэнэ. Зөвлөлийн гишүүд саналын нэг эрхтэй оролцоно.

24. Дэд зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэл гаргах бөгөөд тэмдэглэлийг дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж, дэд зөвлөлийн даргаар гарын үсэг зуруулж албажуулан архивын журмын дагуу бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.

25. Дэд зөвлөлд оролцогч аль нэг тал дэд зөвлөлийн хуралдаан хийх, хэлэлцэх асуудлын санал гаргавал дэд зөвлөлийн дарга хуралдааны бэлтгэлийг хангуулж, хуралдааныг ажлын 14 хоногт багтаан зарлан хуралдуулна.

26. Дэд зөвлөлийн гишүүд нь байгалийн нөөцийн засаглал, засаглалын ил тод байдлын талаарх өөрсдийн санал бодлоо ямарваа хязгаарлалт, албадлагагүй, бусдаас зөвшөөрөл авахгүйгээр үндэслэлтэйгээр илэрхийлэх эрхтэй

27. Санаачлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа баримт бичгийн төсөл, саналыг оролцогч талуудын төлөөллийг оролцуулан боловсруулах хуваарийг дэд зөвлөлийн хуралдаанаас эсвэл түүний чөлөөт цагаар дэд зөвлөлийн дарга төлөөллийн ахлагч нартай зөвшилцөнгаргана.

28. Дэд зөвлөлийн гишүүд баримт бичгийн төслийг боловсруулахдаа санаачлагын зарчим, шаардлагыг баримталж, дотоод, гадаадын туршлага, холбогдох байгууллага, зөвлөх, мэргэжлийн байгууллагын санал, зөвлөлгөөг авах бөгөөд тоо баримт, мэдээллийн үнэн зөвийг боловсруулсан гишүүд хариуцна.

29. Дэд зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн тайлан мэдээ, хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэролон нийтэд нээлттэй ил тод байна. Танилцахыг хүссэн иргэн, иргэний нийгмийн байгууллага, компани, хэвлэл мэдээлэл, төрийн байгууллагын албан тушаалтанд хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл нээлттэй байна.

#### **Дөрөв. Дэд зөвлөлийн зөвшилцөлийн хэлбэр**

30. Дэд зөвлөлийн хуралдааны үед санал зөрүүтэй, маргаантай асуудал гарвал дараахь арга хэлбэрээр зөвшилцөнө.

30.1. Оролцогч талуудын ахлагч нар тухайн маргаантай асуудлаар зөвшилцөх;

30.2. Тухайн маргаантай асуудлаар ажлын хэсэг томилж асуудлыг боловсруулах;

30.3. Дэд зөвлөл нь маргаантай асуудлаар зөвлөх, шинжээчдийн баг томилох, Ажлын хэсэгт уламжлан санал дүгнэлт гаргуулах;

#### **Тав. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл**

31. Дэд зөвлөл нь жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллана. Үйл ажиллагааны төлөвлөгөөг Санаачилгын олон улсын зарчим, шаардлагад нийцүүлэн төлөвлөж хэрэгжүүлэх хугацаа, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хариуцах тодорхой эзэн, үр дүнг хэмжигдэхүйц байдлаар төлөвлөсөн байна.

32. Дэд зөвлөл нь дараах таван чиглэлийн ажлыг онцлон анхаарч хэрэгжүүлж хэвшинэ. Үүнд:

32.1. Ашигт малтмал, газрын тос байгалийн хийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компани тус бүрээр улс, орон нутгийн төсөвтөлсөн татвар, төлбөр, хандив тусламжийг хүлээж авсан, нөгөө талаас төлсөнтайланг талууд жил бүргаргаж хэвлэн нийтлэх, сурталчилах, түгээх;

32.2. Олборлох үйлдвэрлэл эрхлэгч Засгийн газар, орон нутгийн захиргаатай байгуулсан гэрээ түүний хэрэгжилтийн тайланг жил бүр олон талт хэлэлцүүлгээр нээлттэй тайлагнаж хэвлэн нийтлэх, түгээх;

32.3. Орон нутагт олгогдсон бүхий л төрлийн тусгай зөвшөөрлүүд түүний байршил хөдөлгөөнийг тухай бүрт нь ил тод нээлттэй болгох, мэдээллийн цахим болон хэвлэмэл хуудасгаргаж сурталчилах, түгээх;

32.4. Үндэсний болон орон нутгийн Санаачилгын тайлангаар гарсан зөрүү, дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх, түүний ул мөрөөр арга хэмжээ авах, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тусгайлан авч хэлэлцүүлэх;

32.5. Дэд зөвлөлийн үйл ажиллагаа, орон нутаг дахь санаачилгын хэрэгжилтийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр тогтмол сурталчилж байх;

33. Санаачилгын зорилго, зарчим, шаардлага, ач холбогдолын талаар олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, оролцоог хангахад чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагаануудыг тогтмол зохион байгуулах; (Мэдээллийн төв/самбар байгуулах, талуудад сургалт, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах, хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, хэвлэмэл хуудас, материал тараах, нээлттэй утас ажиллуулах, олон талт хэлэлцүүлэг, нэгдсэн чуулганзохион байгуулах гэх мэт )

34. Дэд зөвлөл нь Санаачилгын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс гарсан шийдвэр, зөвлөмжийг орон нутагтаа сурталчилан хэрэгжүүлнэ.

35. Шаардлагатай тохиолдолд дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, үндэсний түвшинд шийдвэрлүүлэх асуудлыг ОУИТБС-ын ажлын албаар дамжуулан Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулж болно.

36. Аймаг нийслэлийн дэд зөвлөл, сум дүүргийн дэд зөвлөлүүдхоорондоо болон Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг, Ажлын алба холбогдох бусад талуудтай зорилго, үйл ажиллагааныхаа хүрээнд нягт уялдаатай, мэдээлэл солилцож эргэх холбоотой ажиллана.

### **Зургаа. Дэд зөвлөлийн үйл ажиллагааны тайлагнал, хяналт**

37. Сум, дүүргийн дэд зөвлөл нь жил бүрийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайланг тухайн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, аймаг, нийслэлийн дэд зөвлөл жил бүрийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайланг сум, дүүргийн дэд зөвлөлийн ажлын тайлантай нэгтгэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус тайлагнана. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлсэн Аймгийн хэмжээний ОУИТБС-ын хэрэгжилтэд өгсөн дүгнэлт, гарсан шийдвэрийн хувийг ОУИТБС-ын ажлын албанд хүргүүлнэ. Ажлын алба аймаг, нийслэлийн дэд зөвлөлийн тайлан мэдээг цахим хуудсанд байршуулан сурталчилах;

38. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах чиглэлээр дэд зөвлөлөөс хийж байгаа үйл ажиллагааны явц, биелэлтийн байдалтай талуудын

төлөөллийн ахлагч, гишүүд танилцаж, явцыг эрчимжүүлэх арга хэмжээ авах талаар саналаа дэд зөвлөлд оруулж байх;

39. Аймаг, нийслэл, сум, дүүргийн дэд зөвлөлийн жилийн төлөвлөгөөт үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийн биелэлт, үйл явц санаачилгын холбогдох хууль тогтоомж, олон улсын зарчим, шаардлагад нийцэж байгаа эсэхэд Санаачилгын Үндсэний зөвлөл, Ажлын хэсэг, Ажлын алба, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага хяналт мониторинг хийхэд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх үүргийг дэд зөвлөл хүлээх;

### **Долоо. Дэд зөвлөлийн санхүүжилт ба бусад асуудал**

40. Дэд зөвлөлийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах захиргааны зардлын бичиг хэрэг, шуудан, харилцаа холбоо, томилолт, сурталчилгаа, хурлын зардлыг аймаг нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын төсөвт тусган Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан санхүүжинэ.

41. Дэд зөвлөлийн жилийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь дотоод, гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өгсөн хандив тусламж, төрийн байгууллагын тусгай сангууд, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөс бүрдсэн байж болно.

42. ОУИТБС-ын ажлын албаны зардалд дэд зөвлөлийн нарийн бичгийн даргыг чадавхижуулах, сурталчилгааны тараах материалыг хэвлүүлэх, сургалтад оролцох зэрэг зардлыг оруулж тооцно.

43. Дэд зөвлөл нь ОУИТБС-ын таних тэмдэг (лого)-г хуралдааны материал, баннер, албан бичиг, ажлын байрны хаяг, вэбсайт, сурталчилгааны материалын толгой болгон хэрэглэж болно.

44. ОУИТБС-ын Ажлын алба нь Санаачилгын орон нутаг дахь хэрэгжилтийг үндэсний хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулж, Дэд зөвлөлийн үйл ажиллагааг олон улсын зарчим шаардлага, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэхэд ажлын удирдамж, арга зүйгээр хангаж ажиллана.

45. Дэд зөвлөл нь Санаачилгын зарчим, шаардлагын агуулга, холбогдох хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэх аливаа асуудлаар ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг түүний гишүүд, ажлын албанаас лавлагаа, мэдээлэл, тараах материал, гарын авлага, арга зүйн туслалцаа авах эрхтэй.

Цахим хуудас: [www.eitimongolia.mn](http://www.eitimongolia.mn); [www.tanevsel.wordpress.com](http://www.tanevsel.wordpress.com);  
[www.miningmongolia.mn](http://www.miningmongolia.mn);

Е-шуудан: [eiti.secretariat.mn@gmail.com](mailto:eiti.secretariat.mn@gmail.com); [eiti.communication@gmail.com](mailto:eiti.communication@gmail.com)  
[pwypmgl@yahoo.com](mailto:pwypmgl@yahoo.com);

утас: 70110525; факс: 70110155



## ОУИТБС-ын хэрэгжилтийг идэвхжүүлэх чиглэлээр 2013 онд зохион байгуулсан сургалт, мэдээллийн ажлын тайлан

2013 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

### 1. Орон нутгийн түвшинд Санаачилгын хэрэгжилтийг идэвхжүүлэх

2012 онд Засгийн газрын 222-р тогтоол батлагдаж, бүх шатны Засаг дарга нарт аймагтаа Санаачилгын дэд зөвлөлийг байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр үүрэг өгөгдсөн байдаг. Орон нутагт Санаачилгын хэрэгжилтийг идэвхжүүлэх чиглэлээр хийсэн эхний алхам бол юуны түрүүнд дээрх тогтоолын хэрэгжилтэнд анхаарч ажиллах тухай Ерөнхий сайдын ахлах зөвлөх Л.Гансүхийн гарын үсэг бүхий албан тоотыг 2013 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 21 аймгийн Засаг дарга нарт хүргүүлж, мэдээлэх явдал байлаа. Шууд хариу ирүүлсэн цөөхөн аймаг байсан ба орон нутагт бүсийн семинар зохион байгуулж, ач холбогдлын талаар мэдээлэл хүргүүлсний дараа аймгууд дэд зөвлөлөө байгуулж, одоогоор нийт 1 нийслэл, 15 аймгийн дэд зөвлөл байгуулагдаад байна. /Хавралт 1-ээс үзэх/

Дэд зөвлөл байгуулсан захирамжуудыг үзэхэд Санаачилгын гол зарчим болсон гурван талын тэнцүү оролцоо гэх зүйл орон нутагт хэрэгжихгүй, ойлголт муутай байгаа нь ажиглагдсан тул дараагийн алхамд дэд зөвлөлийн гишүүдэд Санаачилгын талаар нэгдсэн ойлголт өгөх, үйл ажиллагааны нэгдсэн заавар, журмын төсөл боловсруулж санал авах явдал байв. Улмаар Уул уурхайн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга Ч.Отгочулуутай зөвлөлдөж уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж буй 13 аймгийн нэрс гаргаж, тэдгээр аймгуудын дэд зөвлөлийн дарга/Засаг даргын орлогч,



нарийн бичгийн дарга/АЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудад “ОУИТБС ба дэд зөвлөл” сэдэвт сургалтыг 7 сарын 4-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгууллаа. Сургалтанд 11 аймгийн 47 хүн оролцсон бөгөөд сургалтын эхний хагаст Санаачилгын талаарх ерөнхий ойлголт, Засгийн газрын 222-р тогтоолд заасан дэд зөвлөлийн чиг үүрэг, журмын төслийг танилцуулан, хэлэлцүүлэв. Хоёрдугаар хагаст орон нутгийн төлөөлөгчдийн оролцоотойгоор Санаачилгыг орон нутагт хэрхэн амжилттай хэрэгжүүлэх чиглэлээр бүлгийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, санал зөвлөмж гаргасан болно /Дэлгэрэнгүйг сургалтын тайлангаас үзэх/.



Гуравдугаарт, төлөвлөгөөний дагуу бүсчилсэн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын чуулган”-ыг 4 бүсэд хуваан **Ховд** /баруун бүс, 8 сарын 20/, **Өндөрхаан** /зүүн бүс, 10 сарын 25/, **Дархан** /хойд бүс, 11 сарын 27/, **Улаанбаатар** хот /төвийн бүс, 11 сарын 12/-уудад зохион байгуулав. Чуулганы гол зорилго ОУИТБС-ын хэрэгжилтийг орон нутагт идэвхижүүлэх, бүсийн түвшинд асуудлыг хэлэлцэж, туршлага солилцох, нэгдсэн ойлголтыг бий болгох, аймгуудын дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, гурван талт



хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд оршиж байв. Зохион байгуулалтын тухайд чуулганд төр, компани, иргэний нийгмийн төлөөллийг аль болох тэнцүү оролцуулах, аймаг бүр 1-2 сумын төлөөллийг заавал оролцуулах, сум нь иргэний төлөөллийг заавал оролцуулах зэрэг тэнцүү байх төлөөллийг шаардлагыг түлхүү тавьж байв. Агуулгын хувьд бүсийн чуулганаар орон нутагт хэрхэн тайлан гаргаж, баталгаажуулах вэ? гэрээ, лицензийн ил тод байдлыг хэрхэн хангах уу? санаачилгын үйл ажиллагааг яаж олон нийтэд хүргэх үү? дэд зөвлөлөө хэрхэн байгуулах вэ? зэрэг арга зүйн асуудал, дэд зөвлөлийн журмын төсөлд орох зарчмын асуудлуудыг түлхүү хэлэлцэж, орон нутгийн оролцоотойгоор нэгдсэн санал зөвлөмж гаргахад чиглэж байв /Оролцогчдын тоог Хавсралт 2-оос харах/.




Төлөвлөгөөнд тусгагдаагүй нэг орон нутгийн хэлэлцүүлэг зохион байгуулагдсан нь Говь-Алтай аймгийн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод, нээлттэй байдлын анхдугаар чуулган” байв. Уг чуулганыг 6 сарын 7-ны өдөр Говь-Алтай аймгийн иргэний нийгмийн байгууллагаас санаачилан зохион байгуулж, урилгаар Ажлын хэсгийн зарим гишүүд оролцож, Санаачилгын ач холбогдол, зорилго, үйл ажиллагааны талаар мэдээлэл хийв. Уг чуулганд нийт 250 гаруй төлөөлөгчид оролцсон болно.

Дээрх 6 удаагийн арга хэмжээгээр нийт 20 аймгийн 600 гаруй оролцогчдод Санаачилгын зорилго, ач холбогдол, хэрэгжилтийн талаар мэдээлэл хийж, орон нутагт санаачилгын хэрэгжилт, дэд зөвлөлийн үйл ажиллагааг хэрхэн идэвхжүүлэх чиглэлээр тодорхой чиглэл өглөө. Түүнчлэн тэдгээр оролцогчдоос Засгийн газрын 222-р тогтоолыг хэрэгжүүлэхэд дэд зөвлөлийн журамд тодорхой болгох шаардлагатай асуудлуудын талаар санал, зөвлөмж авч, журмын төслийг шинэчлэн сайжруулж, Ажлын хэсгийн хуралд танилцуулж, батлууллаа.

Оролцогчдыг төлөөллөөр нь авч үзвэл 49% нь төрийг, 29% нь иргэний нийгмийг, 19% нь компанийг, 3% нь бусад төлөөллийг төлөөлсөн байна. Төрийг төлөөлсөн 49%-ийн оролцогчдын 27% нь удирдах албан тушаалтнууд, 23% нь мэргэжилтнүүд байсан бол иргэний нийгмийг төлөөлсөн 29%-ийн оролцогчдын 7% нь ИНБ-аас, 12% нь иргэдийг төлөөлж оролцсон байна. Засаг захиргааны нэгжээр авч үзвэл нийт оролцогчдын 67% орон нутгаас буюу аймгийн төвөөс 35%, сумаас 32%, үлдэх 33 хувь нь Улаанбаатар хотоос оролцжээ.

**Нийт 5 удаагийн семинарын оролцогчдын төлөөлөл**



**2. Сургалт, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа**

Төлөвлөөгөөгөөр компанид 2, төрийн захиргааны байгууллагуудад 1, нутгийн захиргааны байгууллагуудад 1, аймаг, дүүргийн Засаг даргын орлогч нарт 1, иргэний нийгмийн байгууллагуудад 1 нийт 6 удаагийн сургалт зохион байгуулах ёстой байсан. Орон нутагт чиглэсэн үйл ажиллагаагаар буюу 7 дугаар сарын 4-ны сургалт, 4 бүсийн семинараар иргэний нийгмийн байгууллага, Засаг даргын орлогч, нутгийн захиргааны байгууллагууд бүгд оролцож, мэдээлэл авч, сургалтанд хамрагдсан тул дээрх 3 сургалтыг орон нутгийн үйл ажиллагаатай нэгтгэсэн болно. Харин компаниудад зориулсан сургалтыг “Тайлангаа чанартай гаргацгаая” сэдэвтэйгээр 2 сарын 6, 3 сарын 26-ны өдрүүдэд нийт 110 гаруй олборлох үйлдвэрлэлийн компанийн удирдлага, ажилтнуудад зохион байгууллаа. Тус сургалтыг зохион байгуулахад Ашигт малтмалын газар хамтран ажиллаж, компаниудыг оролцуулах тал дээр нилээн идэвхтэй ажиллаж байв. Төлөвлөгөөнд ороогүй боловч Эрдэнэс таван толгой ХК-ний ТУЗ-ын хүсэлтээр тус компанид 11 сарын 22-ны өдөр 15 удирдах ажилтнуудад Санаачилгын сургалтыг зохион байгуулсан болно. Төрийн захиргааны тайлан гаргадаг байгууллагуудын сургалтыг ТЕГ, Сангийн яамтай хамтран 12 дугаар сард зохион байгуулах байсныг 2014 оны 1-р сар болгон хойшлуулав.

ЕСБХБ-ны төслийн хүрээнд Адам Смит байгууллагаас 12 удаагийн сургалт төлөвлөснөөс 8 сургалтыг нь 2013 онд зохион байгуулав. Сургагч багш бэлтгэх сургалт 1, компаниудад зориулсан 2, иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан 2, сэтгүүлчдэд зориулсан 1, төрийн захиргааны төв байгууллагуудад зориулсан 1 сургалтыг тус тус зохион байгуулав. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзэх/



“ОУИТБС-ын дэд зөвлөл ба иргэний нийгмийн оролцоо” сэдэвт  
2013 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн семинарын тайлан

2013 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

“ОУИТБС-ын дэд ба иргэний нийгмийн оролцоо” сэдэвт семинарыг 7 дугаар сарын 4-ний өдөр АА-аас зохион байгуулав. Семинарыг Улаанбаатар хотноо, Скай плаза төв дээр хөтөлбөр ёсоор, зохион байгуулалтын сайн түвшинд зохион байгуулсан болохыг нотолж байна.

Семинарт Архангайгаас 2, Баянхонгороос 4, Говь-Алтайгаас 3, Дорноговиос 2, Дорнодоос-3, Дундговиос 3, Орхоноос 2, Өмнөговиос 3, Сэлэнгээс 3, Төвөөс 2, Ховдоос 3, Улаанбаатараас 17 хүн оролцжээ. Оролцогчдын нэрс, бүртгэлийг хавсаргав.

Семинарын гол сэдвийн дагуу ОУИТБС-ыг орон нутаг хэрэгжүүлэх, түүнд Дэд зөвлөлийг идэвхтэй ажиллуулах, түүнийг орон нутгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд ашиглах болон цаашдаа 3 талын хамтын ажиллагааг үр өгөөжтэй явуулахад анхаарах зүйлийн талаар бүлгүүдийн ажлын хүрээнд хэлэлцэн зохих зөвлөмж саналыг гаргалаа.

Гаргасан зөвлөмжүүд:

1. Дэд зөвлөлийн санхүүжилтийг улсын төсвөөс гаргах бололцоотой тул дэд зөвлөл бүр 2014 оны төсөвтөө зардлаа тусгаж батлуулах хэрэгтэй. Санхүүжилт нь 1-2 удаагийн сургалт, сурталчилгаа тус бүр 2-3 удаа уурхай, эсхүл хайгуулын цэг дээр очиж, ажиллах, танилцах, шалгах ажлын томилолтын байж болно. Гэхдээ өөрийн онцлогоос хамаарч аймаг бүр өөр байж болно.
2. Нутгийн удирдлагын манлайлалыг идэвхжүүлэх үүднээс Дэд зөвлөлийн нарийн бичгийн даргыг аль болох Аймгийн засаг даргын тамгын газрын үйлдвэр үйлчилгээ, нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн мэргэжилтнээр ажиллуулахыг эрмэлзэх ба нарийн бичгийн даргыг Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчөөр ажиллуулж болох эсэхийг дор бүрнээ судлан үзэж, шийдвэрлэхийг хичээнэ. Шаардлагатай гэж үзвэл Үндэсний зөвлөлд танилцуулж шийдвэр гаргуулна.
3. Дэд зөвлөлийг Засгийн газрын 2012 оны 222 тогтоолын дагуу Засаг даргын орлогч удирдах ба харин хуралдааныг 3 тал ээлжлэн удирдаж болно. Дэд зөвлөлийн тухай санамж бичигт хурал ээлжлэн удирдах боломжийг дурдаж өгөх хэрэгтэй. Дэд зөвлөлийн хурлыг 3 сар тутамд зохион байгуулж байхыг оролцогчид зөвлөмж болгожээ.
4. Дэд Зөвлөлийн дэргэд ОУИТБС-ын мэдээллийн төвийг байгуулж болох бөгөөд төв нь нүсэр биш, хөнгөн авсаархан, мэдээлэл өгөх боломжтой байх нь зүйтэй гэж оролцогчид тогтов.
5. Дэд зөвлөл нь Аймгийн иргэний танхимтай аль болох үйл ажиллагаагаа уялдуулж, иргэний оролцоотой, шууд ардчилалыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана. Орон нутагт хүлээн авсан орлогын зарцуулалтыг ил тод болгох талаар туршилтын арга хэмжээ авч, тохиромжтой хэлбэрийг сонгоход дэмжлэг үзүүлнэ.
6. Хариуцлагатай уул уурхайн санаачилгын хүрээнд сумдад зохион байгуулагдсан “Олон талт хамтын ажиллагааны зөвлөл” тэй хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа уялдуулна.
7. Аймгийн ОУИТБС-ын өмнөх оны тайланг дараа оны 4 дүгээр сарын 1-ний дотор тушааж, 6 дугаар сард тайланг хэлэлцэх харин тухайн оны ажлын явц, байгуулсан гэрээний биелэлтийг 12 дугаар сард багтаан хэлэлцэж байна.

8. ОУИТБС-ын тайланг сурталчилахад бүх шатны Засаг дарга, хурлын төлөөлөгчдийг оролцуулна.
9. Компанийн тайланг жил бүр сонсох, хийсэн хөрөнгө оруулалтын ажлыг эргэлзээтэй гэж үзвэл шалгалт зохион байгуулах эрхтэй байх, компаниудаас гаргах тайланд тухайн төслийн үр ашиг, байгаль орчиныг хамгаалах зардлын урьдчилгаа, нөхөн сэргээлтийн зардлын хэмжээг оруулж өгөх хэрэгтэй. Мөн байгаль орчины төлөвлөгөөг хамгаалахад сумын Засаг дарга, байгаль орчины байцаагч тайланг шаардана шүү.
10. Аймаг, сумын тайлангуудыг тухайн аймаг сумдын засаг дарга, ерөнхий нябо нар баталгаажуулахын хамт аймаг компаниудын тайлангийн нэгтгэлийг мөн аймгийн Засаг даргын тамга газраас зохион байгуулна.
11. Тайлангийн маягтын хаягийн хэсгий илүү тодорхой бологх, сумаас компани бүрээр тайланг гаргаж, сумын иргэдийн хурал баталгаажуулан, тогтоол гаргах хэрэгтэй.
12. Сум аймгийн тайлагналын програмыг боловсруулах шаардлагатай байна.
13. Олгосон тусгай зөвшөөрөл, байгуулсан гэрээ сум аймагт танилцуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчид, хувь эзэмшигчдийн талаархи мэдээлэл, техник эдийн засгийн үндэслэлийг Дэд зөвлөлд гарган өгдөг байхаас гадна тэр талаар тодорхой мэдээлэл өгч байх хэрэгтэй байна.
14. Тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг тодорхой болгох, үүний тулд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, иргэдийн эрх ашгийг анхаарч тооцох, байгаль орчины нарийвчилсан үнэлгээг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж байх, хайгуулын тайланг ил тод болгох, байгаль орчины байцаагчийн дүгнэлтийг хамтад нь гаргуулж байх, хайгуулын гүйцэтгэл гэх мэт асуудлыг Дэд зөвлөлд танилцуулж байх хэрэгтэй байна.
15. Баруун бүс нутгийн ОУИТБС-ын чуулганыг Ховд аймагт 8 дугаар сарын 15-20-ны хооронд, Ажлын хэсгийн хуралдааныг Төвийн бүсийн чуулгантай хамтруулан 8 дугаар сарын 25-30 хооронд Дундговь, Дорноговийн аль нэгэнд зохион байгуулж, бэлтгэл ажлаа зохион байгуулахаар тохиролцов. Зүүн бүсийн чуулганыг 10 дугаар сард Дорнод аймагт зохион байгуулах асуудлыг судлахаар болов.
16. Улаанбаатар хотноо 7 дугаар сарын 29-наас 8 дугаар сарын 3-ны өдрүүдэд зохиогдох сургагч багшийн сургалтад дараахь аймгуудаас хүмүүс ирнэ.
  - a. Говь-Алтай Болормаа, ИН
  - b. ...
  - c. ...
  - d. ...
  - e. ...
  - f. ...
17. Эдгээр зөвлөмжинд орсон чиглэлүүдийг ОУИТБС-ын Дэд зөвлөлийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлэхээр тогтов.

Семинарт оролцогсод

**Ховд аймгийн Ховд хотод 2013 оны 8 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баруун бүсийн анхдугаар чуулган, семинар”-ын тайлан**

2013 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

ОУИТБС-ын ажлын алба, Ховд аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран ОУИТБС-ын Баруун бүсийн анхдугаар чуулганыг Ховд хотноо 2013 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Ховд аймгийн ЗДТГ-ын байрны хурлын танхимд зохион байгуулав.

Чуулганы зорилго нь ОУИТБС-ын хэрэгжилтийг орон нутагт идэвхжүүлэх, бүсийн түвшинд уул уурхайн салбар дахь нөхцөл байдлыг хэлэлцэж, туршлага солилцох, нэгдсэн ойлголтыг бий болгох, аймгуудын дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, гурван талт хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд оршиж байв.

Семинарт Ховд аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчны газар, Татварын газар, Мэргэжлийн хяналтын газар, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Баруун бүсийн зөвлөл, аймаг дахь иргэний нийгэм, байгаль орчны иргэний зөвлөлийн төлөөлөл, Цэцэг, Дарви, Мөст, Мянгад сумдын Засаг дарга, Иргэдийн хурлын төлөөлөгч, байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч, ахмад малчин, компанийн төлөөлөл зэрэг 47 төлөөлөгч, Увс аймгийн 10 төлөөлөгч, Завхан аймгийн 11 төлөөлөгч, Баян-өлгий аймгийн 5 төлөөлөгч, Улаанбаатар хотын 6 төлөөлөгч зэрэг нийт 79 төлөөлөгчид оролцлоо.

Нийт оролцогчдын 51% нь төрийн байгууллагын, 38% нь иргэний нийгмийн, 10% нь компанийн, 1% нь аль нэг төлөөллийн бус төлөөлөгчид байв. Компаниудын тухайд Ховд аймагт тусгай зөвшөөрөл эзэмшигч Мо-Эн-Ко ХХК, Алтанрио Монголиа ХХК, Брейвхарт ресорсиз ХХК, Завхан аймагт тусгай зөвшөөрөл эзэмшигч Баян айраг экplorэйшн ХХК, Увс аймагт тусгай зөвшөөрөл эзэмшигч Хар тарвагатай ХК, Баян-өлгий аймагт тусгай зөвшөөрөл эзэмшигч СС Монголиа ХХК зэрэг 6 компанийн төлөөлөгч оролцлоо. Оролцогчдын бүртгэлийг хавсаргав.

Засгийн газрын 2012 оны 222-р тогтоолын дагуу баруун 5 аймаг бүгд ОУИТБС-ын дэд зөвлөлөө шинэчлэн байгуулсан байсан ба Ховд аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн 9 гишүүд, Увс аймгийн дэд зөвлөлийн 5 гишүүд, Баян-өлгий аймгийн дэд зөвлөлийн 2 гишүүд, Завхан аймгийн дэд зөвлөлийн 3 гишүүд баруун бүсийн чуулганд оролцсон нь цаашид өөрсдийн аймгийн дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, чиглэл олж авах түлхэц болж өглөө.

Улаанбаатар хотоос ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүдийг төлөөлж Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Уул уурхайн яамны БХЗГ-ын мэргэжилтэн Б.Хулан, ТЕГ-ын улсын байцаагч Д.Энхтуяа, Авилгатай тэмцэх газрын УССГХэлтсийн мэргэжилтэн Л.Нарантуяа, МБОИЗ-ын УЗ-ийн гишүүн Б.Батболд, Ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар томилогдон ажиллаж, илтгэл тавив.

Семинарыг хөтөлбөрийн дагуу Ховд аймгийн Засаг даргын орлогч М.Амарсанаа нээж, нэгдүгээр хэсэгт Ховд, Завхан, Баян-өлгий, Увс аймгууд дахь уул уурхайн салбарын өнөөгийн нөхцөл байдал, цаашид баримталж буй бодлогын илтгэлийг сонсов. Үргэлжлүүлэн Ховд аймгийн Дарви, Цэцэг сумдын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, Мо-Эн-Ко ХХК, Баян-айраг экplorэйшн ХХК, Алтай бидний шүтээн ТББ-ын илтгэлүүдийг сонсож, холбогдох асуултуудыг тавьж, хариулав.

Семинарын хоёрдугаар хэсэгт, ОУИТБС гэж юу болох, түүнийг хэрэгжүүлэх шаардлага, гарах үр дүн, төрөөс баримталж буй бодлого, компани, иргэний оролцоо, орон нутаг дахь хэрэгжилтийн байдал, санаачилгын шинэ дүрмийн талаар Ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, Уул уурхайн яамны БХЗГ-ын мэргэжилтэн Б.Хулан, МУУҮА-ийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, МБОИЗ-ийн УЗ-ийн гишүүн Б.Батболд, ТЕГ-ын улсын байцаагч Д.Энхтуяа нар илтгэл тавьж, сонирхсон асуултуудад хариулав.

Гуравдугаарт хэсэгт оролцогчдыг гурван бүлэгт хуваан 1) орон нутгийн түвшинд ОУИТБС-ын тайлан гаргах, баталгаажуулах, 2) гэрээг ил тод болгох, үр дүнг тооцох, 3) санаачилгын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, сурталчилах, иргэдийн оролцоог хангах гэсэн гурван сэдвээр бүлгийн хэлэлцүүлэг өрнүүлж, зохих дүгнэлтүүдийг гаргалаа.

Төгсгөлд нь оролцогчдоос семинарын аль хэсэг нь илүү хэрэгцээт мэдээллийг агуулсан талаар судалгаа авав. Судалгааны асуулгыг 42 хүн хариулснаас давхардсан тоогоор нийт оролцогчдын 22 хувь нь тухайн аймаг, сумд дахь уул уурхайн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, 14 хувь нь бүлгийн хэлэлцүүлэг, 11 хувь нь иргэний нийгмийн оролцоо, 18 хувь нь тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй компаниудын танилцуулга, аймаг орон нутгийн тусгай зөвшөөрлийн мэдээлэл нь илүү хэрэгцээтэй байсан гэж хариулжээ

Хүснэгт 1. Асуумжийн үр дүн

Аймгуудын уул уурхайн өнөөгийн нөхцөл байдал	11%
Сумдын уул уурхайн өнөөгийн нөхцөл байдал	11%
Компаниудын танилцуулга	9%
ОУИТБС Монгол Улсад	8%
ОУИТБС Төрөөс баримтлах бодлого	8%
ОУИТБС Компаниудын оролцоо	7%
ОУИТБС Иргэний нийгмийн оролцоо	11%
Тусгай зөвшөөрлийн мэдээлэл	9%
Татвар, төлбөрийн мэдээлэл	6%
ОУИТБС шинэ дүрэм	6%
Бүлгийн хэлэлцүүлэг	14%
Нийт	100%

Түүнчлэн Ховд аймгийн ЗДТГ-тай хамтран орон нутгийн телевиз (Эко ТВ), сэтгүүлчдэд (Монцамэ агентлаг) ярилцлага өгч аймаг, орон нутгийн иргэдэд чуулганаар хэлэлцсэн гол асуудлууд, санаачилгын талаар олон нийтэд мэдээлэл хийх ажлыг зохион байгууллаа.

#### Бүлгийн хэлэлцүүлгээс гарсан дүгнэлтүүд:

- ОУИТБС-ын тайланг орон нутгийн түвшинд гаргах, баталгаажуулах нь:
  - ОУИТБС-ын тайланд тусгагддаг татвар, төлбөр, хандив дэмжлэг, борлуулсан, олборлосон бүтээгдэхүүний тоо хэмжээ зэрэг мэдээллээс гадна орон нутгийн иргэдэд туслан гүйцэтгэгч компаниудын мэдээлэл, лицензийн шилжилт, хөдөлгөөний мэдээлэл, байгаль орчин, эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийн мэдээллийг ил тод болгож, тайлагнуулах шаардлагатайг оролцогчид онцолж байв.

- Түүнчлэн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн санхүүгийн жилийн тайлангаа хүргүүлэхээс өмнө орон нутгийн иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлдэг байхыг онцлов.
- Орон нутагт байгуулагдсан гэрээг ил тод болгох, үр дүнг тооцох нь:
  - Энэ бүлгийн хэлэлцүүлгээс Гэрээг хэнтэй байгуулах нь зохимжтой вэ? Орон нутагт байгуулагдсан гэрээг хэлбэрийн шинжтэй биш яаж бодит ажил болгох вэ? Гэрээнд яаж хяналт тавих вэ? Гэрээний ил тод байдал гэж юу болох? Хариуцлага хэрхэн тооцох? гэсэн асуултуудад хариулахыг зорив.
  - Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулан ажиллана гэж заасан байдаг. Гэхдээ энэ заалтын хэрэгжилт нь аймаг, орон нутгуудад харилцан адилгүй байна. Түүнчлэн тусгай зөвшөөрөл эзэмшигч нэг төрлийн гэрээг багийн засаг даргатай, сумын засаг даргатай, аймгийн удирдлагатай гээд гурван түвшинд байгуулсан байна. Хэлэлцүүлгийн явцад гэрээг хэнтэй байгуулах нь зохимжтой вэ? Баг, сум, аймаг гээд бүх түвшинд байгуулах нь зөв үү? эсвэл дан ганц багийн түвшинд байгуулах нь зөв үү? зэрэг асуултууд урган гарсан бөгөөд дүгнэлт нь гэрээг байгуулахдаа эрх ашгийн эрэмбээр нь эрэмбэлэх нь зүйтэйг онцлов.
  - Орон нутгийн удирдлагатай байгуулсан гэрээ хэлбэрийн шинжтэй байгаа нь гэрээ байгуулахаас өмнө олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулдаггүй, тэдний саналыг тусгадаггүйгээс улбаатай. Ашигт малтмалын тухай хуулийн 42.2-т 42.1-д заасан гэрээг байгуулахаас өмнө нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно гэж заасан байдаг тул энэ хуулийн заалтын хэрэгжилт мөн адил хангалтгүй байгааг харуулав. Иймд аливаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нутгийн удирдлагатай 42.1-д заасан гэрээг байгуулахаар бэлтгэж байгаа бол гэрээ байгуулахаас өмнө заавал олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлэгт нутгийн иргэд сайн оролцож, өөрсдийн саналаа тусгах нь зүйтэй.
  - Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих асуудлын тухайд мөн л АМХ-ийн 42.3-т Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно гэж заасан байдаг тул үүний хэрэгжилтэнд талууд анхаарч ажиллах нь зүйтэй.
- Санаачилгын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх нь:
  - Багийн түвшинд мэдээллийг түлхүү өгөх, ингэхдээ багийн иргэдийн нийтийн хурлаар тогтмол мэдээлж, жилд нэг удаа тусгай сонин хэвлүүлж өрх гэрүүдэд тараах саналыг оролцогчид илүү үр дүнтэй гэж үзэж байв.
  - Тухайн уурхайтай холбоотой мэдээллийг уурхай дээр нь очиж авах шаардлага гардаг боловч хаалттай, оруулахгүй, мэдээллийн самбар нь хэрэгцээт мэдээллийг агуулдаггүй тул компаниудын уурхайн дээрх самбарыг илүү мэдээлэлтэй болгох. Үүнд: тусгай зөвшөөрлийн дагуу эзэмшиж буй талбайн солбицол, байршил, нөөцийн мэдээлэл, хүний нөөцийн мэдээлэл буюу орон нутгаас хэдэн хүн авч ажиллуулсан тоо мэдээ, холбогдох албан тушаалтнуудын холбоо барих хаяг гэх мэт
  - Багийн түвшинд дан ганц мэдээллээд зогсохгүй сумыг бас мэдээллээр хангах нь зүйтэйг зарим оролцогчид онцолж байв. Ингэснээр сумын түвшинд мэдээллээ зангидаж, нэгдсэн бодлоготойгоор багууддаа мэдээлэл хүргүүлэх нь хоорондоо уялдаатай ажиллахад давуу талтайг

онцлов. Ингэхдээ сумын иргэдийн хурал, сумын ЗДТГ-ын мэдээллийн самбараар дамжуулж мэдээлэх нь үр дүнтэй байна.

- Түүнчлэн аймгийн түвшинд мэдээллээ хүргэхийн тулд тусгай ТВ нэвтрүүлэг бэлдэж эсвэл олон талт оролцогчдын хэлэлцүүлгийг шууд дамжуулах саналыг гаргаж байв. Ингэхдээ тухайн нэвтрүүлэг гарах өдөр, цагийг эртнээс аль болох бүх иргэдэд гар утасны мессежээр дамжуулж зар түгээх.
- Компаниудын өөрсдийнх нь вэбсайт илүү мэдээлэлтэй, шинэчлэгддэг байх гэсэн дүгнэлтүүдийг гаргав.

#### Авсан сургамж, цаашид анхаарах асуудлууд

- Энэ удаагийн бүсийн семинарт компанийн төлөөлөл харьцангуй цөөхөн, хангалтгүй оролцсон нь онгоцны нислэгийн билет олдохгүй, хүрэлцээ муу, зардал өндөр, урилгыг богино хугацаанд хүргүүлсэн, компаниудын идэвх оролцоо дутмаг байгаагаас шалтгаалав. Иймд цаашид бүсийн семинарыг зохион байгуулахдаа бүх оролцогчдын хувьд хүрч очиход хялбар, дөт, автомашинаар очих боломжтой байршлыг сонгох нь зүйтэй. Түүнчлэн семинарын урилгыг наад зах нь 1 сарын өмнө удирдлагуудад хүргүүлж, мэдээлэх нь зүйтэй.

Тайлан бичсэн:

Харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа

Тайлантай танилцсан:

Зохицуулагч Ш.Цолмон

**Хэнтий аймгийн Өндөрхаан хотноо 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын зүүн бүсийн анхдугаар чуулган”-ы тайлан**

2013 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр

ОУИТБС-ын ажлын алба, Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран ОУИТБС-ын Зүүн бүсийн анхдугаар чуулганыг Өндөрхаан хотноо 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Хэнтий аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулав.

Чуулганы зорилго нь ОУИТБС-ын хэрэгжилтийг орон нутагт идэвхжүүлэх, бүсийн түвшинд уул уурхайн салбар дахь ил тод, нээлттэй байдлыг хэлэлцэж, туршлага солилцох, нэгдсэн ойлголтыг бий болгох, аймгуудын дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, гурван талт хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд оршиж байв.

Семинарт нийт 88 төлөөлөгчид оролцсоноос орон нутгаас Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын дарга М.Болд, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Д.Эрдэнэбаатар, Байгаль орчны газрын дарга Б.Дархантөр тэргүүтэй нутгийн удирдах албан тушаалтнууд, албан хаагчид, Бор өндөр, Норовлин, Батноров сумдын удирдлага, иргэний төлөөлөл, Бэрх уул ХХК, Лут чулуу ХХК, Дацан трейд ХХК, Зул мөнх бадмаараг ХХК, Бор-өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн төлөөлөл, Сүхбаатар аймгийн Байгаль орчны газрын дарга Х.Төмөрхуяг, Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч Г.Ариунболд тэргүүтэй төрийн албан хаагчид, Бадмаараг хаш ХХК, Монголжүюанли ХХК, Цайрт минерал ХХК зэрэг компаниудын төлөөлөл, Мөнххаан, Онгон, Сүхбаатар, Түвшинширээ, Уулбаян сумдын иргэний төлөөлөл, Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Ц.Баярхүү тэргүүтэй төрийн албан хаагчид, Дашбалбар, Баяндун сумдын удирдлага, иргэний төлөөлөл, Шинь Шинь ХХК, Петрожайна дачин тамсаг ХХК-ийн төлөөлөл бүхий 74 төлөөлөгчид оролцов..

Улаанбаатар хотоос ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийг төлөөлж ТЕГ-ын улсын ахлах байцаагч Я.Пүрвээ, АМГ-ын мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Монголын үндэсний уул уурхайн ассоциацийн Засгийн газар, олон нийттэй харилцах албаны дарга Б.Батбилэг, Төлсөн авснаа нийтэл эвслийн зохицуулагч Н.Баярсайхан, Их баян шарга ТББ-ын тэргүүн Л.Бор, Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцож, илтгэл тавив. Ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүү мэргэжилтэн А.Отгонтунгалаг, ТАН эвслийн гишүүн Л.Отгонцэцэг, Ч.Туяа, Хэнтий аймгийн БОГ-ын мэргэжилтэн Г.Мөнх-эрдэнэ нар чуулганы зохион байгуулалтыг хариуцаж, ТВ9 телевиз бүрэн эхээр нь сурвалжлав.

Нийт оролцогчдын 48% нь төрийн байгууллагын, 20% нь компанийн, 24% нь иргэний нийгмийн төлөөлөгчид байв. Оролцогчдын бүртгэлийг хавсаргав.

Семинарыг хөтөлбөрийн дагуу Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын дарга М.Болд нээж, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн уул уурхайн салбарын өнөөгийн нөхцөл байдал, цаашид баримталж буй бодлогын танилцуулгыг сонсов. Үргэлжлүүлэн Дорнод аймгийн Баяндун сум, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд, Дацан трейд ХХК, Цайрт минерал ХХК, Бор-өндөрийн УБҮ-ийн илтгэлүүдийг сонсож, холбогдох асуултуудыг тавьж, хариулав.

Семинарын хоёрдугаар хэсэгт, ОУИТБС гэж юу болох, түүнийг хэрэгжүүлэх шаардлага, гарах үр дүн, төрөөс баримталж буй бодлого, компани, иргэний оролцоо,

орон нутаг дахь хэрэгжилтийн байдал, санаачилгын шинэ дүрмийн талаар Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, АМГ-ын мэргэжилтэн Д.Мөнхсайхан, ТЕГ-ын улсын ахлах байцаагч Я.Пүрвээ, МУУҮА-ийн ЗГОНХА-ны дарга Б.Батбилэг, ТАН эвслийн зохицуулагч Н.Баярсайхан, Их баян шарга ТББ-ын тэргүүн Л.Бор, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар илтгэл тавьж, сонирхсон асуултуудад хариулав.

Гуравдугаарт хэсэгт оролцогчдыг дөрвөн бүлэгт хуваан 1) дэд зөвлөлийг хэрхэн байгуулах вэ? 2) дэд зөвлөл юу хийх вэ? 3) ямар мэдээллийг ил тод болгох вэ? 4) дэд зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд яаж хүргэх вэ? гэсэн сэдвээр бүлгийн хэлэлцүүлэг хийж, холбогдох зөвлөмжүүдийг гаргалаа.

#### Бүлгийн хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжүүд:

- Дэд зөвлөлийг хэрхэн байгуулах вэ? Чиглүүлэгч: Н.Баярсайхан
  - Дэд зөвлөл нь төр, компани, иргэний нийгмийн тэнцүү төлөөлөлтэй, хэт нүсэр биш байна.
  - Дэд зөвлөлийг аймгийн түвшинд болон уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж буй сумын түвшинд байгуулна.
  - Дэд зөвлөлд орох иргэний нийгмийн төлөөллийг сумын түвшинд багийн иргэдийн нийтийн хурлаар, аймгийн түвшинд иргэний нийгмийн байгууллагуудын нэгдсэн хурлаар тодруулна.
  - Дэд зөвлөлд орох компанийн төлөөллийг тухай аймагт үйл ажиллагаа явуулж буй компаниудын нэгдсэн хурлаар тодруулна.
  - Дэд зөвлөлийн нарийн бичиг нь иргэний нийгмийн төлөөлөл байх нь зүйтэй. Гэхдээ нарийн бичгийн цалингийн асуудлыг шийдвэрлэх гарцыг тодорхойлох шаардлагатай.
  - Сумын түвшинд байгуулах дэд зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг орон нутагт байгуулагдсан бусад олон талт зөвлөлийн бүтэцтэй уялдуулах шаардлагатай.
- Дэд зөвлөл юу хийх вэ? Чиглүүлэгч: Б.Дэлгэрмаа
  - Дэд зөвлөл нь нэн тэргүүнд гурван талын харилцан ойлголцолын санамж бичиг байгуулна.
  - Сумын Иргэдийн нийтийн хурлаар ОУИТБС-ыг сумын түвшинд хэрхэн хэрэгжүүлэх чиглэлээр бодлогын баримт бичиг гаргана.
  - Сумын түвшинд ОУИТБС-ын тайлан гаргана.
  - Сумын түвшинд үйл ажиллагаа явуулдаг ижил төстэй олон талт зөвлөлтэй дэд зөвлөлийн үйл ажиллагааг (санхүү, чиглэл, нэр томъёоны хувьд) уялдуулах уулзалт зохион байгуулж, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудын жагсаалтыг дээд удирдлагад (Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг) уламжилна.
  - Оролцогч талуудын тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлох судалгаа хийнэ.
  - Компаниуд дэд зөвлөлтэй хамтран жилдээ нэг удаа нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж, ОУИТБС-ын тайланг болон бусад мэдээллийг нийтэд мэдээлнэ.
  - Засгийн газрын 222-р тогтоолд заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- Ямар мэдээллийг ил тод болгох вэ? Чиглүүлэгч Ш.Цолмон
  - Аль болох бүх мэдээллийг ил тод болгох, тухайлбал:
  - Лицензийн мэдээлэл /ашигт малтмалын төрөл, талбайн хэмжээ/
  - Олборлосон, борлуулсан бүтээгдэхүүний мэдээлэл
  - ТЭЗҮ-н хураангуй мэдээлэл
  - Хэдэн жилийн хугацаанд олборлолт явуулах мэдээлэл /нөөц/
  - Туслан гүйцэтгэгч нарын мэдээлэл



- Тухайн жилийн нөхөн сэргээлтийн мэдээлэл
- Татвар төлөлтийн мэдээлэл
- Хөрөнгө оруулалтын мэдээлэл
- Дэд зөвлөлийн үйл ажиллагааг болон тайланг олон нийтэд яаж хүргэх вэ?  
Чиглүүлэгч: Б.Батбилэг
  - Багийн иргэдийн нийтийн хурлаар мэдээлэх
  - Ижил төстэй Олон талт зөвлөлд мэдээлэл хүргүүлж, тэднээр дамжуулж мэдээлэх
  - Ил тод байдлын мэдээллийн булан ажиллуулах
  - Компаниудын нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах
  - Аймгийн түвшинд байнгын ажиллагаатай ОУИТБС-ын мэдээллийн төв ажиллуулах
  - Телевиз, радиогоор тусгай нэвтрүүлэг бэлдэж, тогтмолжуулах

Тайлан бичсэн:

Харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа

Тайлантай танилцсан:

Зохицуулагч Ш.Цолмон


## “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын төвийн бүсийн анхдугаар чуулган”-ы тайлан

2013 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр


ОУИТБС-ын төвийн бүсийн анхдугаар чуулганыг 11 дүгээр сарын 12-ны өдөр Улаанбаатар хотын Чингис хаан зочид буудалд зохион байгууллаа.

Төв, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр, Өвөрхангай, Баянхонгор аймгийн нутгийн удирдлага, олборлох үйлдвэрлэлийн компаниуд, уул уурхайн олборлолт бүхий сумдын иргэд, иргэний нийгмийн төлөөлөл, ОУИТБС-ын Ажлын хэсгийн зарим гишүүд нийт 99 төлөөлөгчид оролцов. Нийт оролцогчдын 46% нь төрийн байгууллагыг, 23% нь компанийг, 25% нь иргэний нийгмийг төлөөлсөн байна. Харин засаг захиргааны хувьд ангилан авч үзвэл нийт оролцогчдын 39% нь сумын төвөөс, 29% нь аймгийн төвөөс, 32% нь Улаанбаатар хотоос оролцсон байна. Үүнээс үзэхэд мэдээлэл авсан оролцогчдын дийлэнх нь орон нутгийн тэр дундаа сумыг төлөөлж буй төлөөлөгчид байгаа нь сумын түвшинд ил тод байдлын санаачилгын ач холбогдлыг сурталчилах, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих таатай нөхцөл болов. Төв аймгийн Заамар, Дундговь аймгийн Өлзийт, Дорноговь аймгийн Даланжаргалан, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Говьсүмбэр аймгийн Шивээговь, Өвөрхангай аймгийн Уянга, Нарийнтээл, Баянхонгор аймгийн Галуут сумдын засаг дарга, ИТХ-ын дарга, компани, иргэд, иргэний нийгмийн төлөөлөл оролцсон байна. Оролцогчдын бүртгэлийг хавсаргав.

Хүснэгт 1.



Хүснэгт 2.



Чуулганы зорилго нь ОУИТБС-ын хэрэгжилтийг орон нутагт идэвхжүүлэх, бүсийн түвшинд уул уурхайн салбар дахь ил тод, нээлттэй байдлыг хэлэлцэж, туршлага солилцох, нэгдсэн ойлголтыг бий болгох, аймгуудын дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, гурван талт хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд оршиж байв.

Хөтөлбөрийг боловсруулахдаа мэдээллийг дан ганц нэг талаас өгөх бус орон нутгийн удирдлагуудтай урьдчилан холбогдож санал болгосон сэдвийн дагуу танилцуулга бэлдэхийг урих, тэдний байр суурийг сонсох, харилцан ярилцах, туршлага солилцох замаар ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, түүнийг шийдвэрлэх арга зүйн зөвлөмж боловсруулахад анхаарсан болно.

Улмаар 1) Засгийн газрын 222-р тогтоолын хэрэгжилт сэдвээр Дундговь аймгийн Засаг даргын орлогч Ш.Энхбат, 2) ОУИТБС-ын тайланг орон нутгийн түвшинд гаргах нь

сэдвээр Баянхонгор аймгийн Засаг даргын орлогч Д.Ганбаяр, 3) ОУИТБС-ын тайлангийн ашиглагдахуйц, ойлгомжтой байдал сэдвээр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын орлогч Х.Гэрэлмаа 4) ОУИТБС-ын үйл ажиллагаа, тайланг олон нийтэд сурталчилах нь сэдвээр Дорноговь аймгийн Байгаль орчны газрын дарга Д.Сүрэн нарыг танилцуулга бэлдэж ирэхийг урьж, танилцуулга бэлдэхтэй холбоотой чиглэл, зөвлөгөөг ажлын албанаас тухай бүр өгч ажиллаа.

Чуулганыг ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нээж, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Газрын тосны газрын хэлтсийн дарга Б.Оюун, Татварын ерөнхий газрын ТУБ Д.Энхтуяа, МУУҮА-ийн менежер Б.Батбилэг, ТАН эвслийн зохицуулагч Н.Баярсайхан, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар илтгэл тавив. Мөн БОНХЯ-ны Хүрээлэн буй орчин, нөөцийн газрын ахлах мэргэжилтэн Б.Баярцэцэг, МБОИЗ-ийн УЗ-ийн гишүүн Б.Батболд нар оролцов.

Хоёрдугаар хагаст урьдчилан бэлтгэсэн дээрх 4 сэдвээр дэс дараатай хэлэлцүүлэг өрнүүлж, Н.Баярсайхан, Ш.Цолмон, Б.Дэлгэрмаа нар чиглүүлэгчээр ажиллаж, оролцогч нараас тавьсан санал, зөвлөмжийг тэмдэглэв.

Гаргасан санал, зөвлөмжүүд:

1-р салбар зөвлөгөөн: Засгийн газрын 222-р тогтоолын хэрэгжилт, Дэд зөвлөлийн бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг – Чиглүүлэгч Н.Баярсайхан

- Дэд зөвлөлийг байгуулахтай холбоотойгоор:
  - Бүрэлдэхүүн нь хэт нүсэр биш, талуудын тэнцүү оролцоотой байх, тэр дундаа аль болох олон иргэний нийгмийн төлөөлөлтэй байх
  - Эхний ээлжинд уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй явагдаж буй сумдад дэд зөвлөлийг байгуулах
  - Сумын түвшинд дэд зөвлөлийг байгуулахдаа урьд өмнө нь байгуулагдаад буй ОТХА-ны зөвлөлд түшиглэх
  - ОУИТБС-ыг орон нутагт хэрэгжүүлэхэд сум, багийн иргэд, иргэний нийгмийн байгууллагууд идэвхтэй, үр дүнтэй оролцох, тэднийг чадавхжуулах
  - Төрийн ажилтны ажил үүргийн хуваарьт ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой чиг үүргүүдийг оруулж, хяналт тавих
  - Дэд зөвлөлийн санхүүжилтын асуудлыг шийдвэрлэх
  - Дэд зөвлөлийг даргыг иргэний төлөөлөөс сонгох
  - Дэд зөвлөл нь шийдвэр гаргахдаа бүх гишүүдийг оролцуулсан байх, тэгш оролцоог хангах
  - БХСанд төвлөрч буй хөрөнгийг зарцуулах чиглэлээр тулгарч буй хүндрэлүүдийг бодлогын түвшинд шийдвэрлэх
- Хийх ажлын чиг үүргийн хүрээнд:
  - Талууд харилцан ойлголцолын санамж бичиг байгуулах
  - Хэвлэл мэдээллийн ажилтны ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх
  - Бүх зөвлөлүүдийн гишүүдийг мэдээллээр хангаж, чадавхжуулах, нэгдсэн журам боловсруулж чиглүүлэх
  - Сумын түвшинд уул уурхайн үйл ажиллагаатай уялдан байгуулагдаад буй олон төрлийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг хооронд нь уялдуулах
- Бодлогын асуудлаар
  - Томоохон уул уурхайн компаниудыг дэмжиж, цөөхөн компаниудыг ажиллуулах
  - Нийгмийн хариуцлагын гэрээнд ОУИТБС-ын тайлан гаргах тухай заалт оруулах, тухайн сумандаа ямар нийгмийн хөрөнгө оруулалт хийх талаар нарийн зааж өгөх

- Орон нутгийн шилжүүлэг нь хуулиар заагдсан байдаг боловч хэрэгждэггүй, үүнийг илүү тодорхой болгох
- Төвлөрүүлэх данс нь тодорхой биш байдаг учраас нэгдсэн заавар, зөвлөмж өгөх
- Ихэнх орлого нь ихэнхдээ бэлнээр орж ирдэг. Энэ нь нийгэмд сөрөг уур амьсгал бий болгож байна. Бэлнээр хүлээн авсан бүх орлогыг тайлагнаж байя
- Нөхөн сэргээлтийн асуудлыг ил тод болгох нь зүйтэй.
- Аливаа хөрөнгө оруулалт, хандив дэмжлэгийг шууд нутгийн удирдлага хүлээн авахгүйгээр компани гэрээний үндсэн дээр бүтээн байгуулалт хийж, хүлээлгэж өгөх замаар зохион байгуулах

2-р салбар зөвлөгөөн: ОУИТБС-ын тайланг орон нутгийн түвшинд гаргах нь Чиглүүлэгч Ш.Цолмон

- Хандивийг зөвхөн орон нутгийг хөгжүүлэх сангаар дамжуулан авах
- Олон төрлийн тайлан гаргадаг тул татварын хууль эрх зүйн орчинг сайжруулах
- Нөхөн сэргээлтийн ажлын ил тод байдлын хангах
- Үйл ажиллагаа явуулдаггүй олон лицензтэй компаниудын лицензийн тоог бууруулах
- ААНБуудын бүртгэлийг сайжруулж, хяналт тавих орчинг сайжруулах
- **ААН бүртгэлийг орон нутагт төвлөрүүлэх**
- Тайланг иргэдэд ойлгомжтой байдлаар гаргах
- Нийгмийн хөрөнгө оруулалт хийх чиглэлээр эрх зүйн актууд нь зөрчилддөг тул тодорхой болгох
- **Төр нь төлөх ёстой татварыг бүрэн хүлээн авах чиглэлээр уриалж ажиллах, иргэдийн хяналтыг сайжруулах**
- Төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу тул компанид хүндрэл учруулдаг, нэгдсэн бодлого чиглэл гаргах нь зүйтэй
- Дэд зөвлөлийн даргад улс төрийн албан тушаалтанг томилохгүй байх
- **Компаниудын татварын өртэй эсэхийг хянан шалгаж, нийтэд ил тод болгох**
- Компаниуд нээлттэй байгаа эсэх дээр судалгаа хийж, иргэдэд мэдээлэх
- Хариуцлагагүй компаниудтай дэд зөвлөл нь тулж ажиллах
- Хуулийн дагуу сум, орон нутагт орох ёстой төлбөр, хураамжууд бүрэн төвлөрдөггүй тул хандив дэмжлэгийг өөхшүүлдэг
- Орон нутгийн шилжүүлэг нь практикийн хувьд төсөвт төвлөрөхгүй байгаа тул хуулийн хэрэгжилтэнд анхаарч ажиллах
- Урт нэртэй хуулийн чиглэлээр дэд зөвлөл санал оруулах
- Дэд зөвлөлд ажиллаж буй гишүүдэд урамшуулал олгох
- Дэд зөвлөлийн ажиллах журам нь хэт ерөнхий тул, нарийн тодорхой боловсруулж чиглэл өгөх
- Сургалт мэдээллийн ажлыг нэмэгдүүлэх
- Бичил уурхайчдын асуудлыг ил тод байдлын тайланд оруулах
- Лицензийн мэдээлэл орон нутагт хожуу хүрдэг тул цаг хугацаанд нь тогтмол мэдээлэх

3, 4-р салбар зөвлөгөөн: ОУИТБС-ын тайлангийн ашиглагдахуйц, ойлгомжтой байдал, ОУИТБС-ын үйл ажиллагаа, тайланг олон нийтэд сурталчилах нь Чиглүүлэгч Б.Дэлгэрмаа

- Иргэдэд ойлгомжтой байдлаар тайлагийн маягтыг өөрчлөх
- Иргэд тухайн компани хэдийг олборлов, хэдийг төлөв гэдгийг харьцуулан харах, ойлгох хүсэлтэй байдаг
- Статистикийн хуулинд өөрчлөлт оруулах
- Гэрээний талаарх нэгдсэн ойлголт бий болгох

- Орон нутгийн иргэдэд мэдээллийг ойлгуулах, хүргэх аргачлал боловсруулах
- Уугуул иргэдэд учирч буй нөлөөллийг судалж, асуудлыг хэлэлцэх
- Мэдээллийг түгээх сургагч багшийг орон нутгаас бэлдэж, урамшуулал олгох
- Компани, төрийн байгууллагатай хамтран мэдээлэл хийдэг байх
- Төрийн байгууллагууд ажлын уялдаа холбоогоо сайжруулах
- Мэдээллийн төв байгуулж, түүгээр дамжуулан нийтэд мэдээлэх
- Мэдээллийн төвийн тохижилт, түүнийг хариуцах орон тооны ажилтантай байх
- Мэдээллийн санг АА боловсруулж, түгээх
- Бүртгэлтэй байх, түүнд түшиглэн мэдээллийн санг баяжуулах
- Ажил үүргийн хуваарь тодорхой байх
- Компаниудын уулзалтын хуваарь нийтэд ил тод байх
- Багийн иргэдийн нийтийн хурлаар мэдээлэлээ түгээх нь малчдад илүү хүрнэ
- Компаниудаас ямар байгууллагуудад ямар мэдээлэл гаргаж өгдөг тухай жагсаалт гаргаж байх
- Ашиг тусын талаарх ерөнхий мессежийг нийтэд хүргэх
- Лавлах ном гаргах
- Иргэний танхимд мэдээллийг байршуулах
- Сум, багийн түвшинд ургийн овгийн ахлагч нараар дамжуулан мэдээлэл хийх, сүлжээ байгуулах
- Байгаль хамгаалах идэвхтэн иргэдийг чадавхжуулж, мэдээлэл түгээх
- Гэрээний загвар гаргаж, зөвлөмж гаргаж нийтэд хүргүүлэх
- Олон лиценз олгодог байдлыг хязгаарлах
- Бүртгэлийг орон нутагт шилжүүлэх

Тайлан бичсэн:

Б.Дэлгэрмаа

Хянасан:

Ш.Цолмон

## **“Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хойд бүсийн анхдугаар чуулган”-ы тайлан**

2013 оны 12 дүгээр сарын 11-ны өдөр

ОУИТБС-ын төвийн бүсийн анхдугаар чуулганыг 11 дүгээр сарын 27-ны өдөр Дархан-Уул аймгийн ЗДТГ-тай хамтран Дархан хотод зохион байгууллаа.

Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Булган аймгийн нутгийн удирдлага, олборлох үйлдвэрлэлийн компаниуд, уул уурхайн олборлолт бүхий сумдын иргэд, иргэний нийгмийн төлөөлөл, ОУИТБС-ын Ажлын хэсгийн зарим гишүүд нийт 74 төлөөлөгчид оролцов. Нийт оролцогчдын 46% нь төрийн байгууллагыг, 23% нь компанийг, 23% нь иргэний нийгмийг төлөөлсөн байна. Харин засаг захиргааны хувьд ангилан авч үзвэл нийт оролцогчдын 36% нь сумын төвөөс, 38% нь аймгийн төвөөс, 26% нь Улаанбаатар хотоос оролцсон байна. Үүнээс үзэхэд мэдээлэл авсан оролцогчдын дийлэнх нь орон нутгийг төлөөлж буй төлөөлөгчид байгаа нь аймаг, сумдын түвшинд ил тод байдлын санаачилгын ач холбогдлыг сурталчилах, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих таатай нөхцөл болов. Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө, Баянгол, Дархан-Уул аймгийн Шарын гол, Хонгор, Булган аймгийн Бүрэгхангай, Сайхан сумдын засаг дарга, ИТХ-ын дарга, компани, иргэд, иргэний нийгмийн төлөөлөл оролцсон байна. Оролцогчдын бүртгэлийг хавсаргав.

Чуулганы зорилго нь ОУИТБС-ын хэрэгжилтийг орон нутагт идэвхжүүлэх, бүсийн түвшинд уул уурхайн салбар дахь ил тод, нээлттэй байдлыг хэлэлцэж, туршлага солилцох, нэгдсэн ойлголтыг бий болгох, аймгуудын дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх, гурван талт хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд оршиж байв.

Чуулганыг Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын дарга З.Чүлтэмбат нээж, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Татварын ерөнхий газрын ТУБ Д.Энхтуяа, МУУҮА-ийн менежер Б.Батбилэг, Миний Монголын газар шороо ТББ-ын тэргүүн О.Отгонсайхан, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар илтгэл тавив.

Хоёрдугаар хэсэгт орон нутгийн төлөөллүүд илтгэл тавив. Сэлэнгэ аймгийг төлөөлж АЗДТГ-ын ХБХ-ийн мэргэжилтэн Б.Мөнхбат, Дархан-Уул аймгийг БОГ-ын ахлах мэргэжилтэн О.Хүрэлчулуун, Орхон аймгийг Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Маркетингийн товчооны дарга Д.Галбаатар, Булган аймгийг БОГ-ын мэргэжилтэн Д.Нэмэхбаяр нар илтгэл тавив. Сумдыг төлөөлж Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ЗДО Б.Нармандах, Булган аймгийн Бүрэгхангай сумын ИТХ-ын дарга С.Загас нар илтгэл тавьсан бол компаниудыг төлөөлж Шарын гол ХК, Эрдэнэт үйлдвэр ХХК, Бороо гоулд ХХК-ийн удирдлагууд санал, туршлагаа хуваалцлаа. Харин суман дахь нөхцөл байдал, иргэд юу боддог талаар Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэн М.Даландаваа үзэл бодлоо илэрхийллээ.

Гуравдугаар хагаст оролцогч нарт Засгийн газрын 222-р тогтоол, дэд зөвлөлийн ажиллах журмын төслийг тараасан байсан тул оролцогчдыг компани, төр, иргэний нийгмээр нь ангилан журмын төсөлд өгөх саналыг бүлгээр хэлэлцэв. Хэлэлцүүлгийн өмнө ТАН эвслийн зохицуулагч Н.Баярсайхан өөрийн хийсэн судалгааны үр дүнг, Б.Дэлгэрмаа дэд зөвлөлийн журмын төслийг уншиж танилцуулав.

## Бүлгийн ажлын дүгнэлт, санал

### 1-р бүлэг: Төрийн төлөөлөл

- Дан аймаг, нийслэлийн дэд зөвлөлийн журмын төсөл гэхгүйгээр аймаг, нийслэл, сумын гэж оруулах
- Аймгийн зөвлөлийн төлөөлөлд сумын зөвлөлийн төлөөллөөс оруулах
- Иргэний нийгмийн байгууллага гэсэн төлөөлөлд иргэн гэж тусад нь заавал оруулах
- Дагаж мөрдөх хууль, тогтоомж гэдэг дээр журам, шийдвэр гэж нэмж оруулах
- Дэд зөвлөлийн Нарийн бичгийн дарга нь орон тооны болон орон тооны бус хэлбэрээр ажиллана. Орон тооны бус үед төрийн албан хаагч давхар хашиж болно.
- Санхүүжилт улсын төсвөөс байх
- Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах дагаж мөрдөх журмыг мөрдөж ажиллана гэж оруулах
- Ажлын төлөвлөгөөг засаг дарга батална
- Санамж бичгээр санхүүжилтийг шийдвэрлэх арга замыг тодорхой тусгаж, баримтлах
- Тайлан өгөөгүй аан-үүдийн судалгаа хийх

### 2-р бүлэг: Иргэний нийгмийн төлөөлөл

- Тэнцүү төлөөлөлтэй байна
- Аймгийн түвшинд иргэний нийгмийн төлөөллийг ИНБ-уудын хурлаар, суманд иргэнийг төлөөллөөр сонгоно
- Санхүүжилтыг улсын төсвөөс гаргах
- Баг нь ИНХ-д, сум нь ИТХ-ын хуралд жилд 2-с доошгүй удаа ил тод байдлын талаар тайлагнана
- Тайланг бичгээр, цахим, самбар үзүүлэн байдлаар тайлагнана
- Багийн ИНХ нь иргэний нийгмийг төлөөлж болно.
- Талууд үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө зарчмын зүйлс дээр гэрээ байгуулж ажиллана.
- Сумын нутаг дэвсгэрт А, Х лицензийн дэлгэрэнгүй судалгаа хийнэ
- Сумтай гэрээ хийсэн байдлыг ил болгоно
- Төслийн ТЭЗҮ, БОНБУ-ний тайланг ил тод болгоно
- Дэд зөвлөл нь хяналт тавих бүрэн эрхтэй байх /үүнийг танилцах аялал байдлаар ойлгох/

### 3-р бүлэг: Компанийн төлөөлөл

- Бодлогын түвшинд дараах асуудлуудыг шийдвэрлэх:
  - АМТХ-иар Роялтийн төлбөрийн 10%, 20%, 70% гэсэн шаталсайн байдлаар хуваарилдаг байсныг эргэн мөрдүүлэх
  - Хөгжлийн сан байгуулж зарцуулах
  - Төлсөн авснаа нийтэл гэж байна, гэхдээ энэ нь бодит байдал дээр компаниуд төлснөө л нийтлээд байна, төр нь авснаа бас зарцуулснаа нийтэлдэг байх ёстой.
  - Уул уурхайн хаалтын сан байгуулж хууль эрх зүйн үндэстэй болох
  - Монгол Улсыг 3 бүсэд хувааж /ашигт малтмал/ хөгжлийн загвартай болох
- Журмын төсөлд
  - Дэд зөвлөлийг ИНБ ахлах
  - Журамд хариуцлагын, урамшууллын тогтолцоог оруулах
  - Дэд зөвлөлд орж ажиллах компанийн төлөөлөл нь удирдах ажилтан байх
  - Дэд зөвлөл нь хурлаа компанид, төрийн байгууллагад, баг, сумдын иргэний танхимд ээлжлэн нээлттэй хийх

- Санхүүжилтийг төр хариуцдаг байх

#### Ололт, сургамж

- Дархан-Уул аймаг нь дээрх бүсийн семинарыг зохион байгуулах тухай албан бичгийг ажлын албанаас хүргүүлэхэд шуурхай хариу өгч, хурал зохион байгуулах ажлын хэсэг томилон нягт хамтран ажилласан нь зохион байгуулагчийн талаас их дэмжлэгтэй, сайшаалтай байлаа.
- Гэхдээ Дархан-Уул, Орхон аймаг нь иргэний төлөөллийг хангалтгүй оролцуулсан нь нийт оролцогчдын дунд иргэний төлөөлөл тооны хувьд бага байна гэсэн дүгнэлтийг гаргахад нөлөөлж байв.
- Харин Сэлэнгэ, Булган аймаг нь сумдаасаа иргэдийн төлөөллийг, ИТХ-ын тэргүүлэгчдийг оролцуулж, тооны хувьд бага ч гэсэн чанартай, идэвхтэй оролцоог хангасан, сайн туршлага байв.
- Хойд бүсэд томоохон үйлдвэрлэл эрхэлдэг Бороо гоулд, Эрдэнэт, Шарын гол зэрэг компаниуд илтгэл тавьж, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцсон нь практикт туршлага болохуйц чухал саналуудыг гаргаж байлаа.
- 11-р сарын 28-ны өдөр Дархан-Уул аймагт Швейцарийн хөгжлийн агентлагаас бичил уурхайн асуудлаар бас нэгэн семинар зохион байгуулах гэж байсан нь үйл ажиллагааны хувьд давхардаж оролцогчдыг хувааж байв.
- Гэхдээ тооны хувьд төдийлөн бусад семинаруудтай харьцуулахад бага байсан ч чанарын хувьд нилээн идэвхтэй, асуудал дэвшүүлсэн, шүүмжилсэн, санал тавьсан, товлосон хугацаанаас илүү удаан хугацаагаар асуудлыг хэлэлцсэн ийм ажил хэрэгч, идэвхтэй уур амьсгалтай байлаа.
- Энэ удаагийн хэлэлцүүлэгт Засгийн газрын 222-р тогтоол, дэд зөвлөлийн журмын төслийг хэвлэн тарааж, бүлгийн хэлэлцүүлгээр талуудын төлөөллөөрөө хуваагдан шууд ажилласан нь оновчтой арга зам байв.
- Дараа, дараагийн бүсийн чуулган, сургалт, семинарт Ажлын хэсгээс төлөөлөн оролцож буй оролцогч талууд нэгдмэл байр суурьтай, бие биенийхээ ажлыг хүндэтгэсэн, дэмжсэн байдлаар оролцож, орон нутагт гурван талын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтойг таниулан сурталчилах нь чухал шаардлагатай нь ажиглагдлаа.

Тайлан бичсэн:

Б.Дэлгэрмаа

Хянасан:

Ш.Цолмон